

“ХҮН АМЫН БҮЛГҮҮД, НИЙГМИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР”-ИЙГ 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

(2025 оны жилийн эцэс)

№	Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2025 он			Хариуцах байгууллага	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
					Зорилтот түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Зарцуулсан төсөв, эх үүсвэр			
ЗОРИЛТ-1:ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН ХӨГЖЛИЙГ ХАНГАХ										
1		5.1.1.1. Хүүхдэд чиглэсэн уран бүтээлээр дамжуулан хүүхэд, өсвөр үеийнхэнд соёлын боловсрол олгох	Хамрагдсан хүүхдийн тоо / тухайн жилд /	650	5000	6.0	6.0	СУАЖЗГ, ХЗТ	Тайлант хугацаанд аймгийн Хүүхэд залуучуудын театраас өсвөр насныханд зориулсан, “Шөнийн хунтайж” жүжиг, “Хөгжилтэй аялал” гэсэн 2 уран бүтээлийг шинээр туурвиж 5200 хүүхдэд хүргэж соёлын боловсрол олгосон байна.	100%
2	5.1.1.Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулахад гэр бүлд суурилсан үйл ажиллагааг өргөжүүлж, гэр бүлийн гишүүдэд эрүүл, зөв дадал хэвшлийг бий болгон, хүүхдийн аюулгүй хамгаалагдсан орчинг бүрдүүлж, эцэг, эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэн нийгэмд эерэг өөрчлөлт, хандлагыг бий болгоно	5.1.1.2. Хүүхдийн зөвлөл, оролцооны байгууллагуудыг идэвхжүүлж, “Хөгжлийн хөтөлбөр”, “Зуслан хөтөлбөр”, “Хүүхдийн чуулган” зэрэг арга хэмжээгээр дамжуулан хүүхдийн хөгжил,оролцоог нэмэгдүүлэх	Хамрагдсан хүүхдийн тоо Зохион байгуулагдсан арга хэмжээ /тухайн жилд /	5000 24	8000 27	27.5	27.5	ХГБХХГ	Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах, гишүүдийг чадавхжуулах, нөлөөллийн ажлыг зохион байгуулах чиглэлээр олон арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд зохион байгуулсан 29 арга хэмжээнд 8150 хүүхэд оролцсон. Үүнд: “Зөв ирээдүй–хүүхдийн оролцоо” чуулганд 720 төлөөлөгч хүүхэд, 22 хүүхдийн элч, 24 багийн хүүхэд болон гэр бүлийн нийгмийн ажилтан хамрагдаж, оролцогчдоос гарсан 23 саналыг холбогдох байгууллагад хүргүүлснээр хүүхдийн санал санаачилгыг бодит ажил болгоход чухал алхам болсон. Хүүхдийн зөвлөлөөс зохион байгуулсан “Дархлаа”, “Бүх хайраа гэр бүлдээ”, “Эрүүл мэндийн боловсрол” сургалт, нөлөөллийн 3 ажилд нийт 309 хүүхэд, сум, багийн хүүхдийн чуулган, байгаль хамгааллын чуулганд 2820 хүүхэд, тусгай хэрэгцээт хүүхдэд чиглэсэн “Надад ч бас мөрөөдөл бий” аяны хүрээнд 625 хүүхэд, Үндэсний майхан цугларалтад 425 хүүхэд тус тус оролцооноор хүүхдийн оролцооны цар хүрээг нэмэгдүүлсэн байна. Мөн олон улсын болон үндэсний чуулганд аймгийн хүүхдийн төлөөлөгчид амжилттай оролцооноор хүүхдийн оролцоог шийдвэр гаргах түвшинд хангах, гишүүдийг чадавхжуулах, нөлөөллийн ажлыг бодитой хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн ажил болсон байна. Хүүхдийн зуслангийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Янзага зуслангийн орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор хоолны заал, хүнсний агуулах, талхны цех, захиргааны байр, соёл, урлагийн заалыг засварлах, Канад технологийн хүүхдийн амралтын 4 шинэ байр барихад орон нутгийн төсвөөс нийт 961,0 сая төгрөг зарцуулж ашиглалтад оруулсан. Үүний үр дүнд, 2025 онд Янзага зусланд 1200 хүүхэд амарсан нь өмнөх онтой харьцуулахад 100 хувиар нэмэгдсэн үр дүнтэй байна. Ингэснээр тайлант онд аймгийн хэмжээнд 3 зуслан үйл ажиллагаа явуулж нийт 3251 хүүхэд амарсан байна.	100%

3		5.1.1.3. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлтийг сайжруулж хүүхэд хамгааллын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлтийн тоо / тухайн жилд /	607	200	-	-	ХГБХХГ	<p>Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2025 оноос 2 сум, 29 багт, нийт 24 Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг ажиллуулж, хүүхдийг эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус 22 байгууллагатай хамтран 173 удаагийн сургалт, нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулан нийт 38324 иргэнийг хамруулсан. (Үүнд: 28125 хүүхэд, 10199 насанд хүрэгч байна.)</p> <p>Цахим орчинд хүүхдийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг соёл, урлагийн байгууллага болон ерөнхий боловсролын 7 сургуулийн нийт 430 хүүхэд залуучууд, багш нарыг хамруулсан.</p> <p>Мөн хорт зуршил, үе тэнгийн дээрэлхэлтийн сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй”, “Үе тэнгийн дээрэлхэлт ба түүний хор уршиг”, “Харах өнцөгтэй хайр нэмье” сэдвүүдээр 7 сургуулийн 4190 сурагч, 780 насанд хүрэгчдэд 35 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 6 төрлийн 1535 ширхэг гарын авлагыг түгээсэн.</p> <p>36 сургууль, цэцэрлэгийн 9321 хүүхдэд “Аврагч мазаалай”, “Гүүмби Жүүмби” видео сургалтыг зохион байгуулж, “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөрийн хүрээнд 19 сургуулийн 1521 сурагчийг сургалтад хамруулсан байна.</p> <p>Сум, багийн хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтнууд 77 удаагийн сургалтыг багийн иргэдэд зохион байгуулж 4288 насанд хүрэгчид хамрагдсан байна. Дээрх арга хэмжээнүүдэд улсын төсвөөс 56.0 сая төгрөг зарцуулсан.</p>	100%
4		5.1.1.4. Гэр бүлд чиглэсэн “Бүх хайраа гэр бүлдээ” өдөрлөг, сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж, “Гэр бүлийн цогц төв”-ийг байгуулах	Хамрагдсан гэр бүлийн нийт өрхөд эзлэх хувь	26.6%	33.3%	15.0	15.0	ХГБХХГ	<p>Тайлант хугацаанд гэр бүлийн гишүүдийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гэр бүлийн боловсрол олгох нөлөөллийн аян, өдөрлөг, сургалт, уулзалт зэрэг 62 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 5000 гаруй өрхийн 15000 орчим иргэн хамрагдсан байна. Ингэснээр гэр бүлийн гишүүдийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээнд хамрагдсан өрхийг өмнөх оноос 16.6 хувиар нэмэгдүүлсэн байна. Аймгийн Засаг даргын 2025 оны А/363 тоот захирамжийн дагуу Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Хүүхэд–Хайр–Ирээдүй” уриан дор “Бүх хайраа гэр бүлдээ” сарын аяныг аймгийн хэмжээнд 20 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 7 арга хэмжээг зохион байгуулж, нийт 8385 гаруй иргэнийг хамрууллаа. Үүнд:</p> <p>“Бүх хайраа гэр бүлдээ” өдөрлөгийг Баян-Өндөр болон Жаргалант суманд зохион байгуулж 4114 иргэд оролцсон.</p> <p>“Өглөөний эвент” сургалтыг 12 удаа зохион байгуулж, 20 төрийн болон төрийн бус байгууллагын 480 гаруй ажилтан гэр бүлээрээ оролцож, “Бүх хайраа гэр бүлдээ сэтгэл зүйн өдөрлөг” зохион байгуулан 150 хүн сэтгэл зүйн зөвлөгөө, сургалтад хамрагдлаа.</p> <p>Гэр бүлийн ордонтой хамтран 8 залуу гэр бүлийн</p>	100%

									<p>хурмын ёслолын арга хэмжээний зардлын 50%-ийг хөнгөлж зохион байгуулсан.</p> <p>Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран байгууллагын эцэг эхийн зөвлөлийн гишүүдэд хүүхэд хүмүүжлийн эерэг арга сургалтыг зохион байгуулж 330 гаруй иргэдийг хамруулсан.</p> <p>Гэр бүлтэйгээ цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх гэр бүлийн цаг тооны бичиг, аз жаргалын хуримтлалын хайрцаг, гэр бүлийн тухай хуулийн эмхэтгэл зэрэг гарын авлага тараах материалыг 2700 гаруй иргэнд тархаасан. Мөн бүх хайраа гэр бүлдээ төсөл боловсруулахаар түүврийн аргаар Орхон аймгийн нийт гэр бүлийн 1.2% буюу 361 өрхийн дунд гэр бүлийн суурь судалгааг хийж, гэр бүлд шаардлагатай дэмжлэг, үйлчилгээг үнэлж цаашид авах арга хэмжээ, үйл ажиллагааг төлөвлөх, учирч буй саад бэрхшээлийг тодорхойлох, салбар дундын оролцоог нэмэгдүүлэх “Бүх хайраа гэр бүлдээ” зорилтот төсөл боловсруулсан. Төслийг хамтарсан баг, хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан болон 250 иргэнд танилцуулга, хэлэлцүүлэг хийсэн. Гэр бүлийн ордныг гэр бүлийн цогц төв болгон өөрчлөх зураг төсвийг боловсруулахад шаардлагатай төсвийг 2025 оны орон нутгийн төсөвт тусгуулж, ажлын даалгаврыг батлуулан зураг төсвийг “Үүлэн прожект” ХХК-иар гүйцэтгүүлсэн. Гэр бүлийн цогц төв"-ийг аймгийн Гэр бүлийн ордныг түшиглэн байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна</p>	
5	5.1.1.5.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Нэг анги-Нэг өглөө” арга хэмжээг зохион байгуулж хэвшүүлэх;	Дасгалд хамрагдсан сурагчдын тоо / тухайн жилд/	15000	15500	-	-	БТСГ	<p>“Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье” аяны хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудын бага ангийн сурагчдын дунд “Нэг анги-Нэг өдөр” завсарлагааны цахим дасгалын уралдааныг 2025 оны 11 дүгээр сарын 17-ний өдрөөс 12 сарын 12-ны өдөр хүртэл зохион байгуулж, уралдаанд 22 сургуулийн 196 бүлгийн давхардсан тоогоор 19,200 сурагчдыг хамруулсан.</p>	100%	
6	5.1.1.6.Хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгож үе тэнгийн сургагч багш бэлтгэх	Эрүүл мэндийн боловсрол олгосон хүүхдийн тоо /Өссөн дүнгээр/	-	300	-	-	ЭМГ	<p>Хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тайлант хугацаанд 6 төрлийн үйл ажиллагаа, 69 удаагийн сургалт, 1 удаагийн хэлэлцүүлэг, 16 удаагийн өдөрлөг зохион байгуулж, 19 сургуулийн 5–12 дугаар ангийн 3,013 хүүхдийг эрүүл мэндийн боловсролд хамруулсан байна. Эрүүл мэндийн боловсролыг олон талт хэлбэрээр олгох зорилгоор эрүүл мэндийн 5 төрлийн 3,155 ширхэг гарын авлагыг түгээн ажилласан.</p> <p>Өсвөр үеийнхэнд “Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд” чиглэлээр үе тэнгийн зөвлөгч бэлтгэх сургалтад 21 сургуулийн идэвхтэн 25 хүүхдийг хамруулж, үе тэнгийн зөвлөгчөөр бэлтгэн, мэдлэг, хандлагыг дээшлүүлсэн.</p> <p>Мөн хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулан Эрүүл мэндийн газрын цахим хуудсаар 11 постер, 1 рийл нийт 12 төрлийн мэдээллийг байршуулж, давхардсан тоогоор 22,787 иргэнд түгээсэн байна.</p> <p>Өсвөр насны охидын жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох өдөрлөгт 767 хүүхдийг хамруулж, 6 хүүхдийг эмчийн хяналтад</p>	100%	

									авсан. Тайлант хугацаанд өсвөр үе, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чиглэлээр 2 албан тоот, 2 мэдээлэл боловсруулж, 2 удаагийн дэмжлэгт хяналт хийж, арга зүйн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Эрүүл мэндийн газраас хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 286 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сургуулийн нийгмийн ажилтан, багш нарыг хамруулж, чадавхжуулсан байна.	
7	5.1.1.7.ЕБС, цэцэрлэгүүдийн ачааллыг тэнцвэржүүлж, боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх	Анги дүүргэлтийн норм хангасан бүлгийн эзлэх жин	Цэцэрлэг 22.2% ЕБС 45.5%	Цэцэрлэг 26.2% ЕБС 46.5%	-	-	БГ	2025-2026 оны хичээлийн жилд нийт 38 хүүхдийн цэцэрлэгт 8591 хүүхэд суралцаж бүлэг дүүргэлт 27.9, төрийн өмчийн 31 хүүхдийн цэцэрлэгт 7933 хүүхэд суралцаж бүлэг дүүргэлт 28.9 байна. Төрийн өмчийн хүүхдийн цэцэрлэгүүдээс бүлэг дүүргэлт аймгийн дунджаас доогуур буюу 28.9-өөс доош бүлэг дүүргэлттэй цэцэрлэг 17 байгаа нь нийт төрийн өмчийн цэцэрлэгийн 54.8 хувийг эзэлж байна. Ерөнхий боловсролын 24 сургуулийн 827 бүлэгт 27932 суралцагч суралцаж, бүлэг дүүргэлтийн дундаж 33.7, төрийн өмчийн 17 сургуулийн 697 бүлэгт 24906 суралцагч суралцаж, бүлэг дүүргэлтийн дундаж 35.7 байна. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудаас бүлэг дүүргэлтийн дундаж аймгийн дунджаас доогуур буюу 35.7-оос доош бүлэг дүүргэлттэй 11 сургууль байгаа нь нийт төрийн өмчийн сургуулийн 64.7 хувийг эзэлж байна. Хамран сургах тойргийг шинээр тогтоосон, аймгийн хэмжээнд 2-5 насны хүүхдийн тоо буурсан зэргээс шалтгаалан хүүхдийн цэцэрлэгийн аймгийн дунджаас доогуур бүлэгтэй цэцэрлэгийн эзлэх хувь 3.2 хувиар өссөн. Хүүхдийн цэцэрлэгт суралцаж буй хүүхдийн тоо өмнөх оныхоос 316-аар буурч, бүлгийн тоо 2 оор нэмэгдсэн. Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга шинээр ашиглалтад орсонтой холбогдуулан аймгийн дунджаас доогуур бүлэг дүүргэлттэй сургуулийн эзлэх хувь 12.1 хувиар өссөн.	100%	
8	5.1.1.8.Сургуулийн орчинд хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангаж, үе тэнгийн дээрлэлт болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт, сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагааны тоо /тухайн жилд/	2	2	-	-	БГ	Сургалтын орчинд электрон болон утаат тамхи хэрэглэхийг хориглосон Боловсролын сайдын 2025 оны А/140 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Хүн бүр хүүхэд хамгаалагч” уриатайгаар эцэг эх, асран хамгаалагчдад чиглэсэн “Утаат тамхины хор хөнөөл”, “Та хүүхдээ ажиглаарай” нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 8616 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан. Аймгийн Цагдаагийн газрын алба хаагчидтай хамтран ахлах ангийн 2100 хүүхдэд сургуулийн орчинд үйлдэгддэг болон бусад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж, 2100 сурагчийг хамруулсан байна. Мөн 2025 онд ерөнхий боловсролын сургуулиуд “Дээрлэхэж биш, дэмжиж нөхөрлөө” мэдээллийн	100%	

									самбарыг ажиллуулж хэвшсэн. Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр аймгийн Боловсролын газраас "Гэр айлчлал" арга хэмжээг 2 дахь жилдээ зохион байгуулсан ба сургуулиудын "Хүүхэд хамгааллын баг"-ууд хагас, бүтэн өнчин, дотуур байранд амьдардаг, айлд амьдардаг, эрсдэлт бүлгийн 1192 хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлж, 83 кейс илрүүлж 53 кейс дээр ажиллаж 63.8 хувийг шийдвэрлэсэн байна.	
9	5.1.1.9. Хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг бууруулах олон талт арга хэмжээ зохион байгуулах;	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд)	10.4	10.2	5.0	5.0	ЭМГ	Тайлант хугацаанд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 16 тохиолдол бүртгэгдэж, 1,000 амьд төрөлтөд 8.3 промилль байгаа нь өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор буюу 2.1 промиллоор буурсан үзүүлэлттэй байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн бүтцэд нялхсын эндэгдэл 93.8 хувийг эзэлж байгаа бөгөөд үүнээс 11 тохиолдол буюу 73.3 хувь нь нярайн эндэгдэл, 4 тохиолдол буюу 26.7 хувь нь 28 хоногоос 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл байна. Тайлант хугацаанд нийт 1936 нярай төрснийг эрт үеийн нэн шаардлагатай тусламж, нярайн тандалт болон скрининг шинжилгээнд 100 хувь хамруулсан байна. Нялхсын эндэгдлийг бууруулах зорилгоор боловсруулсан 3 бүлэг, 13 арга хэмжээнээс бүрдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар үнэлэхэд 97.5 хувьтай байна. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт, эмнэл зүйн удирдамж, холбогдох тушаал, зааврын хэрэгжилт, цаг үеийн болон хариу арга хэмжээ, зохицуулалтын талаар сум, өрхийн эмч нарт 6 удаа мэдээлэл, чиглэл өгч, эх, хүүхдийн тусламж үйлчилгээнд 3 удаа дэмжлэгт хяналт хийж, арга зүйн зөвлөмж өгч ажилласан. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/263 дугаар тушаалын дагуу 2024 оны IV улирал, 2025 оны I улиралд бүртгэгдсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн 16 тохиолдолд үзүүлсэн эмнэлгийн тусламжийг хэлэлцэн, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв болон СӨЭМТ-д авч хэрэгжүүлэх 11 шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажилласан. ЭХЭМҮТ, ЭМХТ, Эрүүл мэндийн газраас эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр зохион байгуулсан 18 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 358 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, чадавхжсан байна. Иргэд, олон нийтэд чиглэсэн "Амьдралын алтан 1000 хоног" сэдэвт сургалт, нөлөөллийн ажлыг 2 удаа зохион байгуулж, иргэд болон төрийн байгууллагын ажилтнуудыг хамруулан нийт 354 хүнд хүргэсэн. Мөн Эрүүл мэндийн газрын цахим хуудсаар 7 постер, 3 видео шторк нийт 10 төрлийн мэдээллийг байршуулж, давхардсан тоогоор 18,379 хүнд түгээсэн ба	100%	
10	5.1.1.10. Товлолын дархлаажуулалтын хамрагдалтыг	Товлолт дархлаажуула						Тайлант хугацаанд дархлаажуулалтад хамрагдах ёстой 5,523 хүүхдээс 5,507 хүүхэд хамрагдаж, бүрэн	100%	

		нэмэгдүүлж, халдварт өвчний тохиолдлыг бууруулах.	лтад хамрагдалтын хувь Халдварт өвчний тохиолдол 10000 хүн амд /тухайн жилээр/	99.3 101.7	99.4 101.5	-		ЭМГ	<p>тунгийн хамралт 99.7 хувьтай байна.</p> <p>Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлд нийт 2,872 хүүхдэд тандалт хийж, хэсэг газрын урвал 1, 37.5 хэмээс дээш халууралт 9, ерөнхий урвал 1 тохиолдлыг тус тус бүртгэн мэдээлсэн.</p> <p>Тайлант хугацаанд 2 удаагийн татан авалтаар 20 нэр төрлийн нийт 39,350 хүн тун вакцин, 14,100 ширхэг дагалдах хэрэгслийг хүлээн авч, дархлаажуулалтын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг ханган ажилласан.</p> <p>Дархлаажуулалтын сувилагч нарт мэдлэг сэргээх, чадавжуулах чиглэлээр 10 удаагийн, 10 нэгжийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 170 хүн хамрагдсан байна.</p> <p>Эрүүл мэндийн газар, сум болон Өрхийн эрүүл мэндийн 8 төв хамтран дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, ач холбогдлыг таниулах чиглэлээр 3 удаагийн аян зохион байгуулж, ерөнхий боловсролын 23 сургуулийн 4,500 гаруй сурагч, 2,700 гаруй эцэг, эх, асран хамгаалагчдыг хамруулсан.</p> <p>Мөн 6 удаагийн нөлөөллийн уулзалтад орон нутгийн удирдлага, төрийн болон төрийн бус байгууллага, эрүүл мэндийн салбарын төлөөлөл нийт 100 хүн хамрагдсан бол сургагч багш бэлтгэх сургалтад сурагч, эцэг, эх, асран хамгаалагчдын төлөөлөөс 200 багшийг бэлтгэн чадавжуулсан байна.</p> <p>Хүний папиллома вирусийн (HPV) эсрэг вакцины хамралт 30 хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p> <p>Халдварт өвчний 971 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 91,3 процемилл, байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 10,4 процемиллээр буурсан байна. Нийт халдварт өвчний 40,8% амьсгалын зам, 18,9% БЗДХ, 37,3% бусад халдварт өвчин эзэлж байна.</p>	
11		5.1.1.11. Төрсөн нярай бүрийг скрининг оношилгоонд хамруулж, хяналтад авах, төрөлхийн хөгжлийн гажгийг эрт илрүүлэх	Эрт илрүүлэгт хамрагдсан нярайн тоо /өссөн дүнгээр/	-	1500	-		ЭМГ	<p>Тайлант хугацаанд нийт 1923 эхээс 1936 амьд нярай төрсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төрсөн нярай 81 тохиолдлоор буурсан байна. Төрсөн нярайн 1856 буюу 95.8 хувь нь гүйцэт, 80 буюу 4.1 хувь нь дутуу нярай, 15 буюу 0.8 хувь нь төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн байна.</p> <p>Төрсөн нярайг НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн нярайн тасагт байгуулагдсан АШУУИС-ийн "Нярайн скринингийн салбар төв"-өөр дамжуулан 5 төрлийн эрт илрүүлгийн оношилгоо хийж байна.</p> <p>Нярайн түнхний эход төрсөн 1933 (99.8%) нярайг хамруулж, давтан шинжилгээнд 1715 (88.7%) нярай хамрагдсан байна.</p> <p>Нярайн төрөлхийн дүлийрэл, сонсгол бууралтын эрт илрүүлэгт 1111 нярай буюу төрсөн нярайн 57.4 хувийг хамруулсан. Үүнээс давтан сонсголын скринингт хамруулах шаардлагатай 65 (8.2%) нярайд давтан үзлэг хийж, 2 нярайг чих, хамар, хоолойн эмчид илгээн хяналтад авсан.</p> <p>Бодисын солилцооны 5 төрлийн эмгэгийн эрт илрүүлэгт 1509 нярай хамрагдсан нь төрсөн нярайн</p>	100%

									77.9 хувийг эзэлж байна. Өсгийн хатгалтаар авсан цусны толбоны шинжилгээг долоо хоног бүр нярайн скринингийн оношилгооны лабораторид илгээж байгаа бөгөөд шинжилгээг давтах шаардлагатай 4 (0.7%) нярайг хяналтад авсан байна. Орбис олон улсын байгууллагын санхүүжилтээр, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран "Хүүхдийн нүдний хавдрыг илрүүлэх улаан рефлексийн арга"-ыг нэвтрүүлсэн. Гүйцэт нярайн нүдний эмгэгийн эрт илрүүлэгт 1825 нярайг хамруулж, төрсөн нярайн 100 хувийг хамруулсан бөгөөд эмгэг илрээгүй байна. Дутуу нярайн ретинопатийн оношилгоонд 15 нярайг хамруулж, давтан үзлэгт давхардсан тоогоор 30 нярай хамрагдсан. Үүнээс 1 нярайг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд илгээн хяналтад авсан. Тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 12 төрлийн эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээнд 6408 нярай хамрагдсан байна. Нэг нярай дунджаар 6 эрт илрүүлэг, скринингт хамрагдсан байна.	
					Хэсгийн дүн	53.5	53.5			
12	5.1.2. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тулгамдсан асуудлыг тэдний онцлог, хэрэгцээнд нийцтэй байдлаар хамтын оролцоотойгоор шийдвэрлэж, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэн, нийгмийн тэгш байдлыг бий болгоход чиглэнэ	5.1.2.1.Зорилтот эмэгтэйчүүдэд "Сэтгэл нэмье" сэтгэл зүйн сургалт өдөрлөг зохион байгуулах	бүлгийн чиглэсэн сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо /Өссөн дүнгээр/	50	100	4.0	20.0	ХГБХХГ	Зорилтот бүлгийн эмэгтэйчүүд болон гэр бүлд зориулсан "Сэтгэл нэмье", "Self care" сургалт, бүлгийн зөвлөгөөг 7 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 210 хүнд хүрч ажилласан байна. Мөн ганцаарчилсан зөвлөгөөнд 62 эмэгтэй хамрагдсан. Сургалтаар эцэг эхчүүд, сэтгэл зүйгээ хянах, удирдах аргад суралцаж, эерэг мэдрэмж нэмэгдэх, эерэг уур амьсгал бүрдэх, өөрийгөө ойлгох, хүлээн зөвшөөрөх эхний алхмууд хийгдэж, цаашид тогтмол дэмжлэг авах хэрэгцээг ухамсарлах зэрэг сэтгэл зүйн боловсрол нэмэгдсэнээр гэр бүлийн харилцаа сайжирч, хүүхэдтэйгээ харилцах эерэг арга барилтай болсон. Энэ арга хэмжээнд хөтөлбөрөөс 4.0 сая төгрөг зарцуулсан байна. Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дамжих зорилгоор хөдөлмөрт бэлтгэх ур чадварын сургалтад нийт 162 иргэн бүртгүүлснээс 30 иргэн амжилттай суралцаж чадамжийн гэрчилгээтэй болсон. Энэ арга хэмжээнд хөтөлбөрөөс 8.0 сая төгрөг зарцуулсан байна. Ерөнхий боловсролын сургуулийн өсвөр насны охид, хөвгүүдийн дунд бие биедээ нөлөөлөх, үлгэрлэн дуурай "Роль модель" арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 980 гаруй өсвөр үе хамрагдаж, тулгамдаж байгаа асуудлаа шийдэх, бусдад үлгэрлэх, зөв зүйлд уриалах мэдлэг ойлголтоо нэмэгдүүлсэн. Энэ арга хэмжээнд хөтөлбөрөөс 8.0 сая төгрөг зарцуулсан байна.	100%
13		5.1.2.2. "Эрдэнэт марафон" бүх нийтийн гүйлтийн арга хэмжээг зохион байгуулах	Оролцогч иргэдийн тоо /тухайн жилд/	300	350	-	-	БТСГ	"Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд бүх нийтийн гүйлтийн уралдааныг 2 удаа зохион байгуулж 354 иргэнийг хамруулсан.Үүнд: -"Эрдэнэт марафон-2025" гүйлтийн уралдааныг 2025 оны 05 дугаар сарын 18-ны өдөр А.Амарын	100%

									<p>нэрэмжит талбайд төрийн болон төрийн бус спортын холбоодтой хамтран зохион байгуулсан. Гүйлтийн уралдааныг 5 км, 10 км, 21 км, Гэр бүлийн гүйлт 1500м, Тусгай олимпын иргэдийн 500м-ийн зэрэг 5 зай төрөлд 7 насны эрэгтэй, эмэгтэй ангиллаар зохион байгуулж, Орхон, Булган, Хөвсгөл аймгийн нийт 239 тамирчид, иргэд оролцсон.</p> <p>Гүйлтийн уралдааны зохион байгуулалт, шагнал урамшуулалд аймгийн Засаг даргын 2025 оны А/18 дугаар захирамжаар батлагдсан “Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье” аяны зардлаас 5,2 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.</p> <p>- Шри Чинмойны нэрэмжит бүх нийтийн гүйлтийг 2025 оны 09 дүгээр сард 4 км, 21 км-ийн зайд 7 насны эрэгтэй, эмэгтэй ангиллаар зохион байгуулж уралдаанд 115 тамирчдыг хамруулсан.</p>	
14	5.1.2.3. Эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд эрэгтэйчүүдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх	Эрэгтэйчүүдийн үзлэгт хамрагдалтын хувь /тухайн жилд/	43,6%	44,7%	5.0	5.0	ЭМГ	<p>Тайлант хугацаанд төлөвлөлтийн дагуу “Эрдэнэт Медикал” төрөлжсөн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн 5645 эрэгтэй ажилчид, төрийн болон хувийн хэвшлийн 122 байгууллагын 7506 ажилтан, албан хаагчийг урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамруулан 38%-ийг идвэхтэй хяналтад авсан байна.</p> <p>-Аймгийн Засаг даргын А/820 дугаар захирамжийн хүрээнд ээлжит цэрэг татлагад хамрагдсан иргэд болон хүчний 5 байгууллагын эрэгтэй ажилтан, албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж нийт 1,346 эрэгтэйг үзлэгт оруулан давхардсан тоогоор 2,004 өвчлөлийн сэжигтэй тохиолдол илрүүлэн идэвхтэй хяналтад хамрагдсан. Ээлжит цэрэг татлагаар үзлэгт орсон 499 залуучуудаас 817 өвчлөл илэрч, 129 нь эрүүл мэндийн заалтаар цэргийн албанаас чөлөөлөгдөн, мэдрэл, шүд, чих хамар хоолой, арьс харшил, мэс засал, дотор эрхтэн, халдварт өвчний чиглэлээр зонхилох эмгэгүүд илэрсэн. Мөн элэгний В вирус, тэмбүү, ХДХВ-ийн нийт 6 тохиолдол батлагдаж, холбогдох хяналтад авсан байна.</p> <p>-Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хангах хүрээнд явуулын урьдчилан сэргийлэх үзлэгт Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, 2 их дээд сургуулийн 1029, Хүчний байгууллагын 847 ажилтан, албан хаагчдыг үзлэгт хамруулан илүүдэл жин, хэвлийн өөхлөлт, зүрх судасны эрсдэл, аритми, түрүү булчирхайн эмгэг, харааны өөрчлөлт зэрэг эрүүл мэндийн эрсдэл өндөртэй иргэдийг харьяа өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шилжүүлэн, хяналт, эмчилгээнд хамруулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан. 2025 оны жилийн эцсийн байдлаар 803343 иргэнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан бөгөөд үүнээс 359,898 эрэгтэйчүүдийг хамруулан, хамрагдалт 44.8 хувьтай байгаа нь суурь түвшнөөс 1,2 хувиар нэмэгдсэн байна.</p>	100%	
15	5.1.2.4. Эрэгтэйчүүдийн физиологи, бие бялдрын хувьд	Арга хэмжээний хэрэгжилтийн	-	80%	5.0	5.0	ЭМГ	<p>Хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, ялангуяа эрэгтэйчүүдийг бие бялдрын</p>	100%	

		эрүүл, илүүдэл жингүй байх уриалга, арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулах.	хувь						хувьд эрүүл, илүүдэл жингүй байхад чиглэсэн нийтийг хамарсан 4 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, 37 аж ахуйн нэгж, байгууллагын 8,530 иргэнийг 100 хувь хамруулан эрүүл амьдралын хэв маягийн талаархи мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн. Мөн малчдын эрүүл мэндийн үзлэгт 152 хүн, цэргийн насны 178 залуучуудыг хамруулж, тэдэнд эрүүл амьдралын хэв маягийг таниулах сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг тус тус зохион байгуулсан. Эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний хүрээнд 33 удаагийн мэдээ, сурвалжилгыг орон нутгийн 5 телевизээр, 5 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэн, иргэд олон нийтэд сурталчлан хүргэсэн. 2025 оны жилийн эцсийн байдлаар эрэгтэйчүүдийн дундаж наслалт 72.92, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 83.5 болж, хүйс хоорондын наслалтын зөрүү 10.78 жил буюу өмнөх үетэй харьцуулахад 0.84 жилээр ойртсон эерэг үзүүлэлттэй байна. “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 83,6%-тай үнэлэгдсэн байна.	
16		5.1.2.5 Жирэмсний эрт үеийн хяналтын чанарыг сайжруулах	Жирэмсний эрт үеийн хяналтад хамрагдсан хувь	98.3%	98.4%	5.0	5.0	ЭМГ	Тайлант хугацаанд жирэмсний хяналтад шинээр 1582 эмэгтэй хамрагдсан ба үүнээс эхний 3 сард 1566 эмэгтэй (99.0%) хяналтад орсон байна. Хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээний дүнгээр: <ul style="list-style-type: none"> • Трихомониаз – 33 тохиолдол (2.1%) • Тэмбүү –11 тохиолдол (0.7%) • Заг хүйтэн – 1 тохиолдол (0.06%) • Гепатит В вирус –25 тохиолдол (1.6%) • Гепатит С вирус – 4 тохиолдол (0.3%) байна. Трихомониаз, тэмбүү, заг хүйтэн эерэг илэрсэн 45 тохиолдлын хавьтлын судалгааг гаргаж, хавьтлын хамт 100% эмчилж эрүүлжүүлсэн. Мөн жирэмсний нэрийн хяналт болон жирэмсэн эмэгтэйг хяналтад шилжүүлэх үйл явцад гараас гараар зарчмыг мөрдөж мэдээллийн урсгалыг сайжруулан, зорилтот бүлгийн 1,662 эмэгтэйг үзлэг, шинжилгээнд хамруулсан. Үүнээс: <ul style="list-style-type: none"> • Тэмбүү эерэг – 6 тохиолдол • Трихомониаз эерэг – 1 тохиолдол тус бүрийг хавьтлын хамт 100 хувь эмчилж эрүүлжүүлсэн байна.	100%
17		5.1.2.6. Зорилтот бүлгийн охид, эмэгтэйчүүдэд бэлгийн болон нөхөн үржихүйн талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулагдсан сургалт нөлөөллийн арга хэмжээний тоо Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо	5 1496	8 1692	-		ЭМГ	Тайлант хугацаанд 5 сургуулийн 439 охид болон үзлэгт хамрагдахаар ирсэн 1,496 эмэгтэйчүүдэд 9 удаа дараах сэдвээр танхимын сургалт, брошур тарааж, ганцаарчилсан зөвлөгөө өгч, мэдлэг, хандлагыг нэмэгдүүлсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Хөхний хавдар, хөхөө өөрөө шалгах аргачлал • Өсвөр насны охид, хөвгүүдийн эрүүл мэнд • Гэр бул төлөвлөлт, жирэмснээс 	100%

			/Өссөн дүнгээр/						<p>хамгаалах арга хэрэгслүүд мэдвээр зөвлөгөө мэдээллийг өгсөн.</p> <p>Зорилтот бүлгийн охид, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээг 8 өрх, сумын эрүүл мэндийн төв, Амурлин Тэнгис ТББ, Мишээл НЦО, Хатагтай эмнэлэг зэрэг байгууллагатай хамтран зохион байгуулсан. Үүний үр дүнд:</p> <ul style="list-style-type: none"> • 1,496 эмэгтэй (92.8%) үзлэг, оношилгоонд хамрагдсан • БЗДХ-ыг илрүүлэх шинжилгээнд 812 эмэгтэй, • Эхо оношилгоонд 711 эмэгтэй тус тус хамрагдсаас 192 эмэгтэйд (13%) өвчлөл илэрч, эмчилгээ, хяналтад авсан. <p>Мөн тус хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> • Хөхний үзлэг – 115 эмэгтэй, • Уламжлалт эмчийн үзлэг – 19 эмэгтэй, • Умайн хүзүүний эсийн шинжилгээ – 75 эмэгтэй, • Үтрээний наацын шинжилгээ – 43 эмэгтэйд тус тус хийгдсэн. <p>Үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийг 100% жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийг таниулах сургалт, зөвлөгөөнд хамруулж, шинээр 139 эмэгтэйг гэр бүл төлөвлөлтийн арга хэмжээнд хамруулсан.</p> <p>Үзлэгийн дүнгээр:</p> <ul style="list-style-type: none"> • Үтрээний үрэвсэл – 63 эмэгтэй (33%), • Цэвэршилтийн хам шинж – 32 эмэгтэй (17%), • Сарын тэмдгийн алдагдал – 32 эмэгтэй (17%), • Эрхтэн тогтолцооны эмгэг – 65 эмэгтэй 33% хяналтад авч эмчилсэн. <p>Мөн лавлагаа шатлалд 5 эмэгтэйн мэдээллийг илгээж, БЗДХ-ын илрүүлэлтээр 12 тохиолдол бүртгэгдсэн:</p> <ul style="list-style-type: none"> • Шинэ тэмбүү – 2, • Хуучин тэмбүү – 10, • Трихомониаз – 1 <p>Эдгээрийг хавьтлын хамт эмчилж, эрүүлжүүлсэн.</p>	
18	5.1.2.7.Иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулж, насан туршдаа суралцахуйн үйл ажиллагааг дэмжих	Сургалт үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн орон нутгийн нийт хүн амд эзлэх жин	14.9%	15%	35.0	-	БГ	<p>Аймгийн Насан туршийн суралцахуйн төв 100 гаруй төрийн байгууллага, 4 төрийн бус байгууллага, 2 олон улсын байгууллага, хувийн хэвшлийн 12 байгууллага, 10 иргэнтэй хамтарсан түншлэл, хамтын ажиллагаагаар иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд тус төвөөс 18 багц хөтөлбөрийн хүрээнд 19788 иргэнийг танхимын сургалтад хамруулсан нь нийт иргэдийн 18.02 хувийг эзэлж байна</p>	100%	
				Хэсгийн дүн	60.0	35.0				

19		5.1.3.1.“Залуучууд солилцоо” арга хэмжээг хэрэгжүүлэх	Хамрагдсан залуучуудын тоо /өссөн дүнгээр/	10	22	14.4	14.4	СУАЖЗГ,	Тайлант хугацаанд хүүхэд залуучуудын хөгжил, оролцоог дэмжих зорилгоор хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүй токкацү хөтөлбөр, залуучууд солилцоо арга хэмжээнд нийт 18 хүүхэд, залуус хамрагдсан. Үүнд: Япон улсын Нигата аймагт 2025 оны 10 дугаар сарын 13-20-ны өдрүүдэд нийт 6 хүүхэд “Залуучууд солилцоо” арга хэмжээнд хамрагдлаа. Тус арга хэмжээнд хамрагдсан хүүхдүүдэд мэргэжил сонголтын чиг баримжаа олгох зорилгоор кимоно, сүши, машины үйлдвэр, аялал жуулчлалын цогцолбор болон Японы олон улсын “Васэда” их сургуулийн үйл ажиллагаатай танилцсан байна. Мөн Япон улсын Когани хотын боловсролын байгууллагатай хамтран багш солилцоо арга хэмжээг зохион байгуулж 12 залуу багш, ажилтан тус хотын боловсролын байгууллагад ажиллан туршлага судалсан байна.	100%
20	5.1.3.Залуучуудын сурч боловсрох, хөгжих, манлайлах санаачлагыг дэмжиж, үндэсний өв соёл, түүхээ дээдэлсэн, амьдралын зөв дадал хэвшилтэй, нийгмийн идэвхтэй оролцоо, өндөр бүтээмж бүхий бүлгийг хөгжүүлж, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлнэ.	5.1.3.2. Амжилтай суралцаж байгаа зорилтот бүлгийн хүүхэд, залуучууд гадаад, дотоодын их дээд сургуульд суралцахад нэг удаагийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх	Хамрагдсан залуучуудын тоо /өссөн дүнгээр/	22	25	41.7	41.7	СУАЖЗГ	Амжилттай суралцаж байгаа амьжиргааны түвшин доогуур зорилтод бүлгийн 29 оюутанд 41.7 сая төгрөгийн сургалтын тэтгэлэг олгосон. Аймгийн Боловсролын газраас БНСУ-ын Сүнчон хотын үндэсний их сургуультай 2024 онд байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 оюутан, Сүнчон их сургуулиас ирүүлсэн хүсэлтийн дагуу нэмэлт элсэлтийг зохион байгуулж 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс түргэвчилсэн хөтөлбөрөөр 11 оюутан тус сургуулийн хэлний бэлтгэлд суралцаж байна. Тайлант хугацаанд нийт 23 оюутанд тус бүр 7.0 сая төгрөг, нийт 161.0 сая төгрөгийн тэтгэлгийг орон нутгийн төсвөөс олгосон байна. Элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан 15 сурагчид тус бүр 1.0 төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн ба 2 сурагч Ерөнхийлөгчийн тэтгэлэгт хамрагдсан байна.	100%
21		5.1.3.3. “Иргэний андгай өргөх” ёслол, “Залуучуудын соёлын фестивал” зэрэг эх оронч үзэл төлөвшүүлэх, соёлын боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулах	Хамрагдсан залуучуудын тоо /Тухайн жилд/	120	520	80.8	64.9	СУАЖЗГ	Залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, соёлын боловсрол олгох зорилгоор тайлант онд “Иргэний андгай өргөх” ёслол, “Залуучуудын соёлын фестивал”-ийг зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд нийт 16 удаагийн арга хэмжээ хэрэгжүүлж, 10250 хүүхэд, залуучуудыг хамруулсан. Үүнд: 1.Анхдугаар үндсэн хуулиа баталж, Бүгд найрамдах улсаа тунхагласан өдрийг тохиолдуулан 16 нас хүрч иргэний үнэмлэх шинээр гардан авч буй Ерөнхий боловсролын 22 сургуулийн 100 сурагчийн Монгол Улсын “Иргэний андгай өргөх” ёслолыг зохион байгуулж, орон нутгийн төсвөөс 2.0 сая төгрөг зарцуулсан. 2.Аймгийн Засаг даргын 2025 оны А/780 дугаар захирамжаар “Active youth – 2025” уриан дор “Залуучуудын соёлын фестиваль”-ийг зохион байгуулж, нийт 15 арга хэмжээнд давхардсан тоогоор 10150 залуучуудыг хамруулан, орон нутгийн төсвөөс 62.9 сая төгрөг зарцуулсан. Үүнд: •“Гэр бүлийн үнэ цэн” сургалтад 230 залуучууд хамрагдсан. •Төрийн байгууллагуудад “ACTIVE YOUTH-2025”	100%

									<p>сайн дурын ажилд 420 залуучуудыг хамруулсан.</p> <p>•“ACTIVE YOUTH-2025” сургалт нөлөөллийн арга хэмжээнд 270 залуучууд</p> <p>•“Эрүүл оюутан-Эрүүл ирээдүй” аянд 150 залуучууд</p> <p>•Сэтгэл зүйн зөвлөгөө 520 залуучуудад бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөөг өгсөн.</p> <p>•Аймгийн аварга шалгаруулах сагсны тэмцээн 250 залуучуудыг хамруулсан.</p> <p>•“ACTIVE YOUTH-2025” Залуучуудад зориулсан 8 төрөлт спортын тэмцээн 150 залуучууд хамруулсан.</p> <p>•Явуулын номын сангийн үйлчилгээг 150 залуучуудад хүргэсэн.</p> <p>•“ACTIVE YOUTH-2025” дэвжээ тэмцээнд их дээд сургуулиудын 110 оюутнуудын дунд зохион байгуулсан.</p> <p>•Хойд бүсийн залуучуудын чуулганд аймгийн төлөөлөл болох 50 залуучуудыг хамруулсан.</p> <p>•“Мэдлэг түгээе” подкаст 2800 хандалт авсан.</p> <p>•Залуучуудын хөгжлийн үндэсний чуулганд 510 залуучуудыг хамруулсан.</p> <p>•“Эрүүл мэнд-Эко гороо” аялалд 150 залуучуудыг хамруулсан.</p> <p>•Сайн дурын ажилд 260 залууг хамруулсан.</p> <p>•Хандлагаас хандлага цахим нөлөөллийн ажлыг зохион байгуулж 4130 хандалт авсан.</p>	
22	5.1.3.4.Цахим болон хотын спортын төрлүүдээр тэмцээн уралдаан зохион байгуулах	Зохион байгуулсан тэмцээний тоо /тухайн жилд/	2 удаа	5 удаа	7.0	7.0	БТСГ	<p>Залуучуудын сарын аяны хүрээнд хотын спортын 5 төрлөөр /гар дээр сунилт, гараар таталт, корн холл, хөл бөмбөгийн жонглёр, сагсан бөмбөгийн 3х3 төрөл/ “SparkZ” залуучуудын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 10 дугаар сарын 05-ны өдөр “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-д зохион байгуулж, нийт 500 гаруй залуучуудыг хамруулсан. Тэмцээний зохион байгуулалт, шагнал урамшуулалд аймгийн Засаг даргын 2025 оны А/811 дүгээр захирамжаар батлагдсан 7,0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.</p>	100%	
23	5.1.3.5. Залуучуудын дунд БЗДХ, ХДХВ/ДОХ-ын идэвхтэй тандалт эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулах, халдвараас сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах	Үзлэгт хамрагдсан залуучуудын тоо /тухайн жилд/	4898	5200	9.0	9.0	ЭМГ	<p>Тайлант хугацаанд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 5342 иргэнд ДОХ, тэмбүү илрүүлэх түргэвчилсэн сорил хийсэн байна. Үүнээс халдварт өвчний 971 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 18.2 промиллоор өссөн үзүүлэлттэй байна. Нийт халдварт өвчний бүтэц нь:</p> <ul style="list-style-type: none"> • Амьсгалын замын халдвар – 40.8%, • Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ) – 18.7%, • Гэдэсний халдвар – 3.8%, • Бусад халдварт өвчин – 36.7% байна. <p>Бэлгийн замаар дамжих халдварт өвчний 182 тохиолдол бүртгэгдсэн нь 10,000 хүн амд 17.1 промилло, өмнөх оны мөн үеэс 1.3 промиллоор өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>БЗДХ-ын дүнгээр:</p> <ul style="list-style-type: none"> • Тэмбүү – 40.7%, • Трихомониаз – 42.3%, • Заг хүйтэн – 16.5% <p>тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тембүүгийн өвчлөл 122 тохиолдол буюу 10,0 хүн амд 2.1 промиллоор нэмэгдэж,</p>	100%	

									төрөлхийн тэмбүү 2 тохиолдол бүртгэгдэж 100 хувь эмчлэн эрүүлжүүлсэн байна	
24		5.1.3.6. Цэргийн насны залуучуудын бие бялдрын түвшинг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах	Хамрагдсан залуучуудын тоо (өссөн дүнгээр)	-	30	6.5	-	БТСГ	Тайлант онд Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн хүрээнд Политехникийн коллежийн 104 оюутан, Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн 79 цэргийн насны оюутан залуучууд, цэргийн дүйцүүлэх алба хааж буй 28, нийт 211 оюутан, залуучуудаас бие бялдрын түвшин тогтоох сорил авч, зөвлөгөө өгч ажилласан. Сорилд хамрагдсан 211 оюутан, залуучуудаас Цэргийн насны буюу эрэгтэй 146 оюутан, залуучуудын үнэлгээ: В үнэлгээтэй 2, С үнэлгээтэй – 36, D үнэлгээтэй 56, F- үнэлгээтэй 52 оюутан байна. Сорилд хамрагдсан залуучуудын бие бялдрын түвшинг сайжруулахаар 2 фитнес клубтэй гэрээ байгуулсан боловч Засгийн газрын шийдвэр, төрийн сангийн үйл ажиллагаанаас шалтгаалж аймгийн Засаг даргын 2025 оны А/811 дүгээр захирамжаар батлагдсан 6,5 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулах боломжгүй болсон.	0%
					Хэсгийн дүн	159.4	137.0			
25	5.1.4. Ахмад настны эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн хамгааллын дэмжлэг туслалцаа үзүүлэх үйлчилгээг олон нийтийн оролцоотойгоор сайжруулж, ахмадын нийгмийн идэвхи оролцоо, зөвлөн туслан туслалцаа үйлчилгээг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэх хувилбарт боломжуудыг бүрдүүлж, санхүүгийн чадавхийг дээшлүүлэн амьдралын чанарыг сайжруулна.	5.1.4.1. Ахмад настанг дэмжихэд чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулах;	Зохион байгуулсан арга хэмжээний тоо /Тухайн жилд/	20	23	90.0	82.5	Ахмадын хороо, Анхдагчдын холбоод	Хөтөлбөрийн хүрээнд ахмад настнуудад чиглэсэн олон талт үйл ажиллагааг аймгийн Ахмадын хороотой хамтран зохион байгуулах зардалд 45.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Дэмжлэгийн хүрээнд Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр 350 эмэгтэй, Зэвсэгт хүчний 104 жил, Монгол цэргийн бахархлын өдөрт зориулсан хүндэтгэлийн арга хэмжээнд 200 ахмад, "Ахмадууд дуулж байна" дуун цэнгүүнийг сар бүр зохион байгуулж, нэг удаад 38-50 хүн хамрагдаж нийт 5 удаагийн арга хэмжээнд 200 гаруй ахмад хамрагдсан бол Ахмад настны тухай хуулийг сурталчлан таниулах зорилгоор 5 багц сэдэв бүхий сургалтыг Ахмадын ордны сургалт, мэдээллийн танхим болон багуудын Иргэний танхим, Соёлын төвүүдэд 26 удаа зохион байгуулж нийт 885 ахмадыг хамруулсан. Мөн сургагч багш нар НБХ, ТББ, ХХҮГ-уудтай хамтран 1397 ахмадын оролцоотой сургалтыг зохион байгуулж "Цахим ахмад" хөтөлбөрийн хүрээнд 25 ахмадыг "Хурдан клуб"-т суралцуулж байна. Нийт 36 удаагийн сургалт, мэдээллийн арга хэмжээг зохион байгуулахад 2307 ахмад хамрагдсан. Ахмад настны хуулийн хэрэгжилтийн хүрээнд Ахмадын баярын өдрийг 7 өдрийн турш Орхон аймгийн 2 сум, 29 багийн 18000 гаруй ахмадууд болон багуудын залуучууд, хүүхдүүдийн төлөөлөл 5135 хүний оролцоотой "6+1" арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. Аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээнд 182 ахмад, софт волейболд 5 бүсийн 20 тамирчин, шатар, даамны тэмцээнд 52 ахмад тус тус хамрагдсан. Баян-Өндөр сумын 100 ахмад настныг өдрийн үйлчилгээнд хамруулсан. Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн	100%

									<p>хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд анхдагч илгээлтийн эздэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг жилийн турш зохион байгуулах зардалд МАНЗ-Баатар холбоо-7.0 сая, төрийн байгууллагуудын Соёмбо холбоо-7.0 сая, Эрдэнэтийн овооны анхдагч илгээлтийн эздийн холбоо-12.0 сая, Барилгачин дайчдын холбоо-4.0 сая, Залуу насаа эргэн дурсахуй холбоо-3.0 сая, Анхдагч багш нарын Эрдэм холбоо-2.5 сая, Далан гурав далан найм холбоо-2.5 сая төгрөг олгосон боловч Далан гурав далан найм холбоо 0.5 сая төгрөгийг авч чадалгүй төсөв хаагдсан. Мөн "Эрдэнэт хотын болон Анхдагч илгээлтийн эздийн өдөр"-өөр зарцуулах байсан 7.0 сая төгрөгийг томуу, томуу туст өвчний дэгдэлт их байсантай холбогдуулан үйл ажиллагааг зохион байгуулалгүй төсвийг татуулсан.</p> <p>Анхдагч илгээлтийн эздийн дунд зохион байгуулах олон талт үйл ажиллагааны зардалд 37,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тус дэмжлэгийн хүрээнд хүнд нөхцөлд амьдарч буй 11 анхдагчид тусламж, хэвтрийн өвчтэй 32 анхдагчид гэрийн эргэлт, ахмадын сувилалд 43, өдөр өнжүүлэх үйл ажиллагаанд 21 анхдагч тус тус хамрагдсан. Тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээг 3, сургалтын үйл ажиллагаа 2, туршлага судлах уулзалт аялал 1, спортын урлагийн тэмцээн тус бүр 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 1100 гаруй анхдагч, ахмадууд хамрагдсан байна.</p>	
26	5.1.4.2.Ахмад настанд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;	Нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан ахмадын тоо /тухайн жилд/	1785	2000	-	-	ХХҮГ	<p>Аймгийн Ахмадын хороо, Жаргалант сумын Ахмадын хороотой хамтран лавлагаа, мэдээлэл, хууль, эрх зүй, сайн дурын үйлчилгээ, ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө, ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээ, ахмад настны зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ зэрэг "Идэвхитэй насжилтыг дэмжих үйлчилгээ"-нд 568 ахмад настанг хамруулж, нийт 56.6 сая төгрөгийг олгосон. Ахмадын зориулалттай амралт, сувиллын газарт амарч сувилуулсан 1366 ахмад настны хөнгөлөлтийн 336.4 сая төгрөгийг нийгмийн халамжийн сангаас олгосон. Ахмад настныг асарч буй 1450 иргэнд 4.1 тэрбум, ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид 4289 ахмадад 1.2 тэрбум, насны хишиг 6632 ахмадад 974.0 сая төгрөгийн тусламжийг тус тус НХСангаас олгосон.</p>	100%	
27	5.1.4.3. Ахмад настныг эрүүл мэндийн сэргээн засах тусламж үйлчилгээнд хамруулах;	Хамрагдсан ахмадын тоо /тухайн жилд/	9800 /давхардсан тоогоор/	9800	1.0	1.0	ЭМГ	<p>Орхон аймагт ахмад настны тусламж үйлчилгээг эрүүл мэндийн анхан шатны 9 байгууллага, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн ахмадын кабинет, Эрдэнэт сувилал, клиник нийт 11 байгууллага үзүүлж 10,316 (77.5%) ахмадад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.</p> <p>Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамруулах эрүүл мэндийн 1 мэргэжилтний саналыг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт хүргүүлж 1 эмчийн материал тэнцэж түр ажлын байраар хангагдсан ба тухайн мэргэжилтэн ахмад настны гэрийн сувилахуйн талаар бусад ахмадуудаа эрүүл мэндийг дэмжих 1000 цагийн сургалтыг зохион байгуулахаар</p>	100%	

									төлөвлөсөн. Нийт сэргээн засах тусламж үйлчилгээг 3120, өдрийн эмчилгээ 1250, оношилгоо, шинжилгээнд 5841 ахмад хамрагдсан байна.	
28		5.1.4.4. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдсан ахмадын тоо /өссөн дүнгээр/	61	65	-		ХХҮГ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд өрхийн хөдөлмөр эрхлэн өөрсдийгөө ажлын байраар хангаж байгаа 21 ахмад настанд нийт 197.0 сая төгрөгийн хүүгүй, барьцаагүй зээлийг 24 сарын хугацаатай олгож санхүүгийн дэмжлэгт хамруулсан. Мөн аймгийн Ахмадын хороо, Баян-Өндөр сумын ЗДТГ-тай хамтран багууд болон ахмадуудын хөгжил оролцоог хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын гишүүн ахмадуудад 6х20 хэмжээтэй 18 хүлэмжийг хүлээлгэн өгснөөс 9 ахмад хүлэмжийн тариалалт хийж, хавар, зун, намрын улиралд амжилттай ажиллуулж байна. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах хүсэлт ирүүлсэн 17 байгууллагын 39 ахмад настантай гэрээ байгуулан 42.1 сая төгрөгийн урамшууллыг ХЭДС-аас олгосон. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх шаардлага хангасан 7 ТББ-тай хууль эрх зүй, боловсрол, инженер техникийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ өгөхөд нь 197.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр 2 ахмад настантай гэрээ байгуулан ажиллаж 3 сарын урамшуулалд 3.8 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон. Нийтдээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд 71 ахмад настан хамрагдсан.	100%
29		5.1.4.5. Асаргаа сувилгааны үйлчилгээг шаардлагатай ахмадуудад үзүүлж, асаргаа сувилгааны төв байгуулах;	Асаргаа сувилгаанд хамрагдсан ахмадын тоо /тухайн жилд/	450	550	-		ХХҮГ	Ахмад настны тухай хуулийн хүрээнд Баян-Өндөр, Жаргалант суманд "Ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ", Жаргалант суманд "Ахмад настныг өдрөөр асрах үйлчилгээ, Гэрээр асрах /явуулын/ үйлчилгээ" үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж Баян-Өндөр, Жаргалант сумдын Ахмадын хороод шалгарч дээрх үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэснээр Баян-Өндөр суманд 568, Жаргалант суманд 200 ахмад хамрагдан лавлагаа, мэдээлэл, хууль, эрх зүй, сайн дурын үйлчилгээ, ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө, ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээ, ахмад настны зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээнүүдийг үзүүлсэн. Аймгийн ИТХ-ын хурлаар батлуулсан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийж гүйцэтгэх ажлын жагсаалт батлагдсаны дагуу аймгийн ХХҮГ-ын дэргэдэх Ахмадын сувиллыг "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний асаргаа сувилгааны төв" болгон өөрчлөн зохион байгуулж, "Хөвсгөл хамгаалал"ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэхээр 2025 оны 12 дугаар сард үйл ажиллагааг эхлүүлсэн.Тус төвөөр нийт 30 гаруй ахмадад асаргааны үйлчилгээг үзүүлсэн. Асаргаа сувилгаа, идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээнд нийт 798 ахмад хамрагдсан байна.	100%
					Хэсгийн дүн	91.0	83.5			
30	5.1.5.Хөгжлийн	5.1.5.1. Хөгжлийн бэрхшээлтэй	Соёлын арга	700	850	10.0	8.5	СУАЖЗГ,	Тайлант хугацаанд соёл урлагийн байгууллагуудаас	100%

<p>бэрхшээлтэй иргэд бие даан амьдрахад шаардлагатай хүртээмжтэй, тохируулгад орчныг бүрдүүлж, бие махбодийн болон сэтгэл зүйн сэргээн засах тусламж үйлчилгээг нэмэгдүүлэн, тэдний хөгжил, оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин санхүүгийн чадавхыг дээшлүүлнэ.</p>	<p>иргэд, хүүхэд залуучуудад соёл, үйлчилгээгээр дамжуулан хөгжил оролцоог нэмэгдүүлэх;</p>	<p>хэмжээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд /тухайн жилд/</p>				<p>БТСГ, ХХҮГ</p>	<p>зохион байгуулсан 18 удаагийн соёл, олон нийтийн арга хэмжээнд давхардсан тоогоор 468 иргэн, БТСГ-аас зохион байгуулсан спортын 10 төрлийн 13 удаагийн тэмцээн уралдаанд 472 иргэн, нийт 940 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг урлаг соёл, спортын арга хэмжээнд хамруулсан байна.</p> <p>Тухайлбал Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас аймгийн ЗДТГ-тай хамтран "Залуучуудын хөгжил-оролцоо-өөрчлөлт" чуулганыг зохион байгуулж, 500 залуучууд оролцсоноос хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл 15 иргэн оролцсон байна.</p> <p>Мөн БТСГ, Спортын анагаах ухааны эрдэм шинжилгээний төвтэй хамтран аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тамирчид, тэдний гэр бүл, асран хамгаалагчдаас биеийн бүтэц, "InBody" үйл ажиллагаа, булчингийн ажиллах чадварын сорил авч, "Идэвхтэй хөдөлгөөн, спортын бэлтгэл дасгалжуулалт, зөв гүйх арга техник" сэдвээр сургалт зохион байгууллаа. Энэ сургалт арга хэмжээнд 117 иргэн хамрагдсан.</p> <p>Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, бодлогын уялдаа холбоо" сэдэвт сургалт Төр, ТББ-уудын төлөөллийг хамруулан зохион байгуулж 75 хүн, Харилцааны гайхамшиг ТББ-тай хамтран эцэг эх, асран хамгаалагчдад сэтгэл зүйн бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөө үзүүлэх 2 өдрийн сургалт зохион байгуулж 60 хүн, ХБХЭЭХ-той хамтран "Хөдөлмөр эрхлэхэд хаалгаа нээцгээе" өдөрлөгийг 2 өдөр зохион байгуулж 80 гаруй хүн, "Монгол абилемп-2025" улсын уралдаанд Гэрэл төвийн залуучуудыг 8 залуучуудыг оролцуулах зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж нийтдээ 223 хүн хамрагдаж 9.7 сая төгрөг зарцуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, залуусыг хөгжүүлэх, нийгэмшүүлэх чиглэлээр ажиллаж байгаа ХБХЭЭХ-ны Орхон салбар "Гэрэл" залуучуудын төв, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуусын "Найдвар" төв, аутизм, хэл заслын "Пондолдой" төв, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах "Сорхугтани" төв, "Хүмүүн бие даан амьдрах" төв, Хараагүйчүүдийн үндэсний холбооны Орхон аймгийн салбар, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт сургалтын төв" зэрэг нийт 7 ТББ-д орон нутгийн төсвөөс 342.5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлж хамтран ажиллаж байна. Эдгээр ТББ-уудаас ХБХЭЭХ-ны Орхон салбар "Гэрэл" залуучуудын төв Германы элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр мах махан бүтээгдэхүүн боловсруулах төсөл, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй "Хамтын оролцоотой орон нутагт-хүртээмжийг үнэлэх нь" төсөл, Хүмүүн бие даан амьдрах төв "Хувийн туслах үйлчилгээ" төсөл, "Хараагүйчүүдийн холбоо "Брайл үсэг" төслийг тус тус хэрэгжүүлсэн. Гэрээлэн ажиллаж буй 7 ТББ-ууд эцэг эх, асран хамгаалагчдын сургалт, брайл үсгийн сургалт, хуулийн мэдлэг олгох зэрэг сургалт, өдөрлөг уулзалт хэлэлцүүлэг зэрэг 15 удаагийн сургалт</p>
---	---	---	--	--	--	-------------------	---

									нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж нийт 650 гаруй хүн хамрагдсан. Нийтдээ арга хэмжээнүүдэд 873 хүн хамрагдсан.	
31	5.1.5.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын тэмцээн уралдаан зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх	Тэмцээн уралдаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо /тухайн жилд/	360	370	20.0	-	БТСГ	Тайлант онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын 10 төрлөөр 13 удаа тэмцээн уралдаан, арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 472 иргэдийг хамруулсан. Тэмцээн уралдаан, сургалт арга хэмжээний зардалд улс, орон нутгийн төсвийн 17,4 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан. Спортын анагаах ухааны эрдэм шинжилгээний төвтэй хамтран өсвөр, насанд хүрэгч, тусгай олимпын хүүхэд зэрэг бүлгийг хамруулан бие бялдрын Inbody сорил авах, спортын шинжлэх ухааны сургалт зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлж аймгийн хэмжээнд нийт 200 гаруй хүн хамрагдсанаас 80 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байсан. Хүмүүн бие даан амьдрах төвөөс санаачлан бусад ТББ-уудтай хамтран байгууллага тус бүр 5 ААНБ хамруулан хүртээмжийн үнэлгээ хийж, зөвлөмж өгөх, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж нийт 15 байгууллагын 120 гаруй хүнд сургалт нөлөөллийн ажлуудыг зохион байгуулсан. Улаанбаатар хотоос Хөгжлийн бэрхшээлтэй хүний цогц институт ТББ-тай хамтран "Тохируулгатай ажлын байр" сургалтыг 45 аж ахуй нэгж байгууллагын 70 хүний нөөцийн ажилтан болон холбогдох ажилтнуудыг хамруулан зохион байгуулж дээрх ажлуудад нийтдээ 20.2 сая төгрөг зарцуулсан. Тайлант хугацаанд хүүхдийн спортын наадмын төрлүүд болох хөнгөн атлетик, пара бочи, тусгай бочи, модон саваа, 3*3 сагсан бөмбөг, 100 буудалт даам зэрэг тэмцээнүүдэд 30 тамирчин, суугаа волейбол, хонхтой бөмбөг, ширээний дуут бөмбөг, гүйлтийн цана, цасны гуталтай гүйлт зэрэг аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд 110 тамирчид тус тус хамрагдсан. Аймгийн ЗДТГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, ЭМГ, БТСГ, БГ зэрэг төрийн байгууллагууд хамтран тэгш эрхийн сургалт, асран хамгаалагчдын сургалт, нөхөн үржихүйн боловсрол олгох сургалт, дохионы хэлний 3 удаагийн сургалт, багш нарыг чадавхжуулах зэрэг нийт 20 гаруй удаагийн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж явуулж 500 гаруй хүнийг хамруулсан. Нийт арга хэмжээнүүдэд 730 хүн хамрагдсан.	100%	
32	5.1.5.3. Ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн хамран сургалтыг нэмэгдүүлэх	Цэцэрлэг ЕБС-д хамарагдаж буй ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн эзлэх жин	ЕБС 51.1% Цэцэрлэг 85.4%	ЕБС 53.1% Цэцэрлэг 86.4%	-	-	БГ	Тайлант хугацаанд орон нутгийн төсвийн 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3, 5 дугаар сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих "Хүүхдийн хөгжлийн танхим"-ыг байгуулсан. Ингэснээр аймгийн хэмжээнд 11 сургуулийн "Хүүхдийн хөгжлийн танхим"-д 260 гаруй хүүхэд 220 багш ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байна. Эдгээр танхимуудын үйл ажиллагааг эцэг эх, асран хамгаалагчдад сурталчлах, хамтарч ажиллах зорилгоор "Ойлгоё, хайрлая, дэмжье" өртөөчилсөн арга хэмжээг зохион байгуулж 60 гаруй эцэг эх, асран хамгаалагч хамрагдсан байна. 2025-2026 хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 261, хүүхдийн	100%	

									цэцэрлэгт 88, нийт 349 хөгжлийн ялгаатай суралцагч хамрагдаж байгаагаас ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр 252 хүүхэд, эрүүл мэнд хөгжлийн онцлогоос шалтгаалж хүүхдийн цэцэрлэгт 6 настай 19 хүүхэд суралцаж байна. Өнгөрсөн жилтэй харьцуулахад 1 дүгээр ангид элсэн суралцагчид 59.6 хувиар өссөн. Ялгаатай хэрэгцээтэй 1-5 насны 102 хүүхэд байгаагаас 88 хүүхэд буюу 86.6 хувь, 6-18 насны 490 хүүхэд байгаагаас 261 буюу 53.2 хувь нь боловсролд хамрагдаж байна.
					Хэсгийн дүн	30.0	8.5		
					Нийт	393.9	317.5		

ЗОРИЛТ-2:НИЙГМИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙГ ХАНГАХ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2025 он			Хэрэгжилт	Хэрэгжилийн хувь	
				Зорилтот түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Зарцуулсан төсөв			
1.БОЛОВСРОЛ									
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа : 5.2.1.Нийгмийн салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг сайжруулж, хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлтийг оновчтой болгоно.									
1	5.2.1.1	Боловсролын салбарын хүний нөөцийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хувь	-	Бодлогын баримт бичиг боловсруулсан байна.	-	-	Боловсролын салбарын хүний нөөцийн бодлогын баримт бичгийг 5 зорилт 14 арга хэмжээтэйгээр боловсруулж дууссан ба 2026 оноос хэрэгжилтийг хангахаар төлөвлөсөн.	100%
2	5.2.1.2	Боловсролын салбарын хүний нөөцийн бүрдүүлэлтийг хийх арга хэмжээг багш бэлтгэдэг их дээд, сургуулиудтай хамтран зохион байгуулах	Хүний нөөцийн бүрдүүлэлтийн хувь	92%	94%	-	-	Багшийн дутагдлыг нөхөх арга хэмжээний хүрээнд дутагдалтай байгаа багшийн судалгааг ерөнхий боловсролын сургуулиудын 2025 - 2028 оны хүүхдийн тоо анги бүлгийн тоонд үндэслэн гаргасан. Тайлант хугацаанд МУБИС-ийн Архангай аймаг дахь салбар сургуулийн төгсөх ангийн оюутнуудыг аймагтаа дадлага хийлгэж, 16 оюутан Орхон аймагт багшаар ажиллах хүсэлтээ ирүүлснээс 7 төгсөгч ажиллаж байна. 2025-2026 оны хичээлийн жил эхлэхэд ерөнхий боловсролын сургуулиудын 92 сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлагдаж 78 сул ажлын байрыг нөхөж, үлдсэн 14 сул орон тоонд тэтгэвэрт гарсан багш болон цагийн багш нарыг ажиллуулж дутагдлыг нөхсөн.Тайлант хугацаанд шинээр их дээд сургууль төгссөн, Улаанбаатар хот болон хөдөө орон нутгаас шилжиж ирсэн нийт 50 багшийг аймгийн удирдлагууд хүлээн авч уулзалт хийж шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүнийг олгосон. Тайлант хугацаанд багшийн дутагдлыг 98.4%-иар нөхсөн байна.	100%
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа : 5.2.2.Нийгмийн салбарын гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийн сургалт, хөгжлийг бодит хэрэгцээнд тулгуурлан дэмжиж, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, бүтээмжийг дээшлүүлж, судлаач албан хаагчдыг бэлтгэнэ.									
3	5.2.2.1	Багш ажилтнуудын хөгжлийг дэмжих, масс сургалтын чанарыг дээшлүүлэх, ахлах сургуулийн багш нарыг бэлтгэх чиглэлээр төрөл бүрийн сургалтуудыг мэргэжлийн байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	ЕБС-76.3% СӨББ-90.4%	ЕБС-76.5% СӨББ-90.6%	15.0	15.0	Бага боловсрол: МУБИС-тай хамтран бага ангийн багш нарын онол арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хүндэвтэр бодлого бодох арга зүй, математик сэтгэлгээг хөгжүүлэх бодлого бодох чадварыг сайжруулах сургалтыг 2025 оны 12 дугаар сарын 24 -26 -ны өдрүүдэд зохион байгуулж 280 багш хамрагдсан. Сургалтын хүрээнд "Арифметикийн өгүүлбэртэй бодлого" олимпиадыг зохион байгуулж 268 багш оролцсоноос 1-р байранд 5 дугаар сургуулийн багш Г.Ариунжаргал, 2-р байранд 4 дүгээр сургуулийн багш С.Одзаяа, 14 дүгээр сургуулийн багш Е.Батхишиг, 3-р	100%

								<p>байранд 14 дүгээр сургуулийн багш Г.Ариунаа, 15 дугаар сургуулийн багш Э.Мөнгөнцэцэг, 1 дүгээр сургуулийн багш Г. Бямбадорж, тусгай байранд 1 дүгээр сургуулийн багш Ц.Нинжбадгар, 4 дүгээр сургуулийн багш Ц. Сувд-Эрдэнэ, 8 дугаар сургуулийн багш Ш.Алтаннамар, 15 дугаар сургуулийн багш Э.Мөнхжаргал нар тус тус шалгарсан байна.</p> <p>Бага ангийн багш нарын монгол хэлний онол арга зүйг сайжруулах, сурагчдын уншаад ойлгох чадварыг хөгжүүлэх хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуур, шалгуурт суурилсан хичээлийн төлөвлөлт, гэрийн даалгавар боловсруулах гэсэн агуулгаар захиалгат сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 10 –ны өдөр МУБИС-ийн багш П.Одсүрэнтэй хамтран зохион байгуулж, 85 багш, 18 сургалтын менежер хамрагдсан. Дээрх 2 удаагийн сургалт, багш нарын олимпиадын шагналын зардалд хөтөлбөрөөс 4.0 сая төгрөг зарцуулсан</p> <p>Бүрэн дунд боловсрол:</p> <p>Тайлант хугацаанд МУИС, МУБИС, "Билигт өргөө", "Эрдмийн сан" сургуулийн математикийн багш нарын баг хамтран нийгэм судлал, англи хэл, математикийн багш нарыг хамруулан "Ахлах ангийн сонгон судлах хөтөлбөрийн хүнд агуулгын онол, арга зүйн сургалт"-уудыг зохин байгуулсан. Сургалтад нийгмийн ухааны 85, англи хэлний 115, математикийн 98 багш хамрагдсан. Эдгээр сургалтуудыг зохион байгуулахад хөтөлбөрийн зардлаас 3.0 сая төгрөг зарцуулсан. Мөн нийгмийн ухаан, биологи, монгол хэл, орос хэл, англи хэлний масс чанарын уралдааныг 2 удаа зохион байгуулж ерөнхий боловсролын 8-12 дугаар ангийн давхардсан тоогоор 15097 сурагч хамрагдсан. Олимпиадад амжилттай оролцсон багш, сурагчдын шагналын зардалд хөтөлбөрөөс 8.0 сая төгрөг зарцуулсан байна.</p> <p>Дээрх ажлуудын үр дүнд ЕБС, СӨБ-ын багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж өссөн байна. Тухайлбал 2025 онд ЕБС-ийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд төрийн өмчийн 17 сургуулийн 968 багш хамрагдаж, үнэлгээний дүн 77.57%, өмнөх оны үнэлгээнээс 1.15%-иар, хүүхдийн 31 цэцэрлэгийн 322 бүлгийн багш хамрагдаж үнэлгээний дүн 94.68%, өмнөх оны үнэлгээнээс 4.78%-иар тус тус ахисан байна</p>	
4	5.2.2.2	Багш, сурагчдын дунд ЭЕШ-ын чанарыг дээшлүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулах	ЭЕШ-ын аймгийн дундаж	540.8	542.0	5.0	5.0	<p>Тайлант хугацаанд ЭЕШ-ын чанарыг сайжруулах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран 2 удаагийн урьдчилсан цахим сорилыг зохион байгуулж хөтөлбөрийн зардлаас 5.0 сая төгрөг зарцуулсан. 2024-2025 хичээлийн жилд 12 дугаар ангийг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн 22 сургуулийн 56 бүлгийн 1591 хүүхэд төгссөн бөгөөд нийт төгсөгчдийн 97.1 хувь нь элсэлтийн шалгалтад бүртгүүлж оролцсон. Элсэлтийн шалгалтын 10 судлагдахууны аймгийн дундаж 516.85 байгаа нь улсын дунджаас 16.4 пунктээр өндөр үзүүлэлт бөгөөд улсын хэмжээнд 4 дүгээрт эрэмбэлэгдсэн байна. Элсэлтийн шалгалтын 10 судлагдахуунаас 5 судлагдахуунаар 15 сурагч 800 оноо авч, 2 сурагч Ерөнхийлөгчийн тэтгэлэгт хамрагдсан байна.</p>	0%
5	5.2.2.3	Багш ажилтнуудыг гадаад туршлага судлуулж, шинэ арга зүй, туршлагыг хичээл сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх	Гадаадад туршлага судалсан багш, ажилтнуудын тоо	27 багш, ажилтан	-	-		<p>Тайлант хугацаанд Япон улсын хүүхэд хүмжүүлгийн эерэг арга зүй "Токкацү" арга зүйг судлах арга хэмжээнд ерөнхий боловсролын сургууль болон Боловсролын газрын төлөөлөл багш, сургалтын менежер, арга зүйч, нийт 10 багш, ажилтан хамрагдсан байна.</p> <p>Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан.</p>	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй
6	5.2.2.4	Сургууль, цэцэрлэгийн багш нарын дунд ур чадвар, арга зүйн уралдааныг зохион	Сургалтын үйл ажиллагаанд	10 (2023)	-	5.0	5.0	<p>Тайлант хугацаанд "Хамтдаа хөгжье-Харилцан суралцъя" ур чадварын уралдааныг амжилттай зохион байгуулж 32</p>	100%

		байгуулах	шинээр нэвтэрсэн арга зүйн тоо					<p>цэцэрлэгийн 32 багш амжилттай оролцсон. Уралдаанд 21 дүгээр цэцэрлэгийн багш Н.Отгонжаргал ахлах бүлэгт "Математикийн энгийн төсөөлөл", 7 дугаар цэцэрлэгийн багш Ш.Мөнгөнзул ахлах бүлэгт "Хэл яриа", 10 дугаар цэцэрлэгийн багш Б.Отгончимэг ахлах бүлэгт "Байгаль, нийгмийн орчин", Баян-Өндөр цэцэрлэгийн багш Д.Мягмарсүрэн бэлтгэл бүлэгт "Математикийн энгийн төсөөлөл" олгох сургалтаар тус тус тэргүүн байранд шалгарсан байна. Ур чадварын уралдаанд сургалт үйл ажиллагаа удирдсан багш нарын бичлэгийг аймгийн "Багшийн арга туршлагын цахим сан"-д байршуулж түгээн дэлгэрүүлж, харилцан суралцах боломжийг бүрдүүлсэн. Энэ уралдааны үр дүнд үндэслэн багш нарыг үнэлгээний арга зүйд суралцуулах шаардлага үүссэн тул Боловсролын үнэлгээний төвтэй хамтран "Явцын үнэлгээний даалгаврыг танин мэдэхүйн түвшнээр боловсруулах арга зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулж сургалтад 80 багш, арга зүйч хамрагдсан байна.</p> <p>Мөн мэргэжлийн багш нарын бүлгийн тэргүүн туршлага шалгаруулах хэлэлцүүлэг арга хэмжээг зохион байгуулж нийт 31 цэцэрлэгийн 34 тэргүүн туршлага, аймгийн хэмжээний судлагдахуунд суурилсан МБНБ-ийн 8 туршлага танилцуулагдаж 6 бүлгийн туршлагыг шалгаруулж урамшуулал олгосон. Энэ үйл ажиллагаагаар багш нар ажлын байрандаа сонирхол хэрэгцээндээ суурилсан мэргэжлийн бүлгээр хамтран ажиллах арга зүй, хүүхэдтэй ажиллах арга зүй, эцэг эхтэй ажиллах, мэдээллийн технологи болон хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй, чадварт суралцсан байна. Тайлант хугацаанд СӨБ-ын сургалтад нийт 10 шинэ туршлагыг нэвтрүүлж түгээн дэлгэрүүлсэн байна.</p>	
7	5.2.2.5	Багш, ажилтнуудын эрдэм, шинжилгээ, судалгааны ажлын арга зүйг дэмжих эрдэм, шинжилгээ онол, практикийн бага хурлыг зохион байгуулах	Судалгаа, шинжилгээний ажил хийсэн багшийн хувь	-	100%	5.0	5.0	<p>Тайлант хугацаанд Боловсролын ерөнхий газартай хамтран сургалтын байгууллагын сургалтын чанар, хүүхдийн хөгжил хамгаалалд тулгамдаж буй асуудал, шийдлийг эрэлхийлэх, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор багш нарын дунд эрдэм, шинжилгээ онол, практикийн бага хурлыг 3 салбар хуралдаанаар зохион байгуулж 2-р шатанд 42 илтгэл хэлэлцүүлэгдсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. "Ерөнхий боловсролын сургуулийн түншлэл, хамтын ажиллагаанд тулгамдаж буй асуудал, шийдэл" салбар хуралдаанд 11 илтгэл 2. "Боловсролын сургалтын байгууллагад эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг, тулгамдаж буй асуудал, шийдэл" салбар хуралдаанд 13 илтгэл 3. "Ерөнхий боловсролын бие даасан байдал, сургалтын чанарт тулгамдаж буй асуудал, шийдэл" салбар хуралдаанд 18 илтгэл <p>Салбар хуралдаан бүрээс шилдэг 3 оролцогчийг шалгаруулж 9 багш, удирдах ажилтныг хөтөлбөрийн хүрээнд шагнаж урамшуулсан. Эдгээр шилдэг илтгэлүүдийг "Bagsh.edu.mn"-платформд байршуулан улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлж, хуралд хэлэлцүүлэгдсэн 42 илтгэлээр эмхэтгэл хэвлүүлж сургалтын байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>Эрдэм шинжилгээний хурлыг 2 үе шаттайгаар зохион байгуулсан бөгөөд 1-р шатны шалгаруулалт сургалтын байгууллагууд дээр явагдаж хамрагдвал зохих багш нар 100% хамрагдаж өөрийн хийсэн судалгааны ажлаа хэлэлцүүлсэн байна.</p>	100%
8	5.2.2.6	Сайн хичээл үйл ажиллагааны зөвлөгөөн туршлага судлах арга хэмжээ зохион байгуулах	Зөвлөгөөнд хамрагдвал зохих багш нарын хамрагдалтын	100%	-	7.0	7.0	<p>Тайлант хугацаанд хөтөлбөрийн хүрээнд дараах 4 үйл ажиллагааг зохион байгуулсан.Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сайн хичээл, үйл ажиллагааны туршлага судлах 	100%

			хувь					<p>зөвлөгөөн хэлэлцүүлэг:</p> <p>Сайн хичээл үйл ажиллагааны зөвлөгөөн туршлага судлах арга хэмжээг сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн суурь боловсролын багш нарын арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх, багшийн хөгжлийг дэмжих зорилгоор сургалтын байгууллага болон аймгийн түвшинд зохион байгуулж хэлэлцүүлэг тус бүрд төрийн өмчийн 17 сургуулиас шалгарсан багш нарын тэргүүн туршлага танилцуулах нийт 51 арга зүйн илтгэл танилцуулагдсан. Хэлэлцүүлгийг БСҮХ, БҮТ, “Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг”-ийн багш, мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулсан бөгөөд 700 гаруй багш хамрагдсан байна. Хэлэлцүүлэгт амжилттай оролцсон 9 багш, багш нараа ажилттай бэлтгэж оролцуулсан 3 сургалтын менежерийг хөтөлбөрийн хүрээнд шагнаж урамшуулсан.</p> <p>2. Судлагдахуун бүрийн үнэлгээний арга зүйн хэлэлцүүлэг</p> <p>Тайлант хугацаанд “Үнэлгээний арга зүй-үр дүн” хэлэлцүүлгийг зохион байгуулж 118 багш, удирдах ажилтан хамрагдсан. Хэлэлцүүлэгт хамрагдсан багш, ажилтнууд сургалтын чанарын өнөөгийн байдал, үнэлгээнд нөлөөлж буй хүчин зүйлс, ахиулах арга зам шийдлийг тодорхойлж, үнэлгээнд суурилсан төлөвлөлт, хэрэгжүүлэлт, ахицыг тооцох, сургалтын чанарыг бодитоор ахиулах арга зүйд суралцсан. Уг хэлэлцүүлэгт 118 багш, удирдах ажилтан хамрагдсан. Тус хэлэлцүүлэгт илтгэлээ амжилттай хэлэлцүүлсэн 3 багшийг хөтөлбөрийн хүрээнд шагнаж урамшуулсан.</p> <p>3. Үнэлгээний арга, үнэлгээнд суурилсан төлөвлөлт, хэрэгжүүлэлт хэлэлцүүлэг, туршлага судлах сургалт үйл ажиллагаа</p> <p>БҮТ-тэй хамтран зохион байгуулсан “Үнэлгээний арга, үнэлгээнд суурилсан төлөвлөлт, хэрэгжүүлэлт” сургалтыг ЕБС-ийн 693 багшийг хамрууллаа. Сургалтаар сургалтын байгууллага болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээний зохион байгуулалт, үр дүн боловсруулалт дээр БҮТ-ийн мэргэжилтнүүдтэй санал солилцож сургалтын байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээг ахиулах төлөвлөлтийг боловсруулсан.</p> <p>4. Үнэлгээний үр дүн боловсруулах, шинжилгээ хийх арга зүй сургалт</p> <p>Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан “Үнэлгээний үр дүн боловсруулах, шинжилгээ хийх арга зүй” сэдэвт 30 хоногийн цахим, 2 өдрийн танхимын сургалтад Боловсролын газрын арга зүйчид, ЕБС-ийн сургалтын менежер, МБНБ-ийн ахлагч, нийт 38 ажилтан хамрагдаж, аймгийн сургагч багшаар бэлтгэгдсэн. Сургагч багшаар бэлтгэгдсэн багш, сургалтын менежер, арга зүйч нар 2025 оны багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, 12 сард зохион байгуулсан ТТШ-ийн дүн, даалгаварт анализ, шинжилгээ хийж сургалтын чанарын үзүүлэлтийг сайжруулахад анхаарах асуудал, сургалтын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, 2026 оны 03 –р сард хийх хөндлөнгийн үнэлгээний даалгаврын бюпринтыг боловсруулсан.</p> <p>Дээрх үйл ажиллагаануудад хамрагдвал зохих багш нар 100 хувь хамрагдсан байна.</p>	
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа : 5.2.3.Нийгмийн салбарын хүний нөөцийн сэтгэл ханамжийг дээшлүүлж, албан хаагчдын амжилтыг үнэлж, урамшуулна.									
9	5.2.3.1	Мэргэжил үр чадвараа дээшлүүлэх чиглэлээр багш, ажилтнуудаас гаргасан санал, санаачилгыг дэмжих	Санал, санаачилга дэмжигдсэн багшийн тоо	9 багш, ажилтан	3 багш, ажилтан	5.0	-	Тайлант хугацаанд ЕБС, СӨБ-ын багш нараас мэргэжлийн онолын мэдлэг чадвар, багшлахуйн арга зүй, суралцахуйн арга барил хөгжүүлэх талаар хэрэгцээний судалгааг авсан бөгөөд судалгааны үр дүнд үндэслэн Боловсролын судалгааны	100%

								үндэсний хүрээлэн, “Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг”, Боловсролын үнэлгээний төвтэй хамтран 12 модуль сургалтын хөтөлбөр боловсруулсан. Боловсруулсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан сургалтад 1407 багшийг хамруулж мэргэжил ур чадвараа дээшлүүлэх чиглэлээр багш, ажилтнуудаас гаргасан санал, санаачилгыг дэмжсэн байна.		
10	5.2.3.2	Багшийн нэр хүнд үнэлэмж, ёс зүйг дээшлүүлэх, багш мэргэжлийг сурталчлах олон талт арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	4	4 арга хэмжээ	18.0	18.0	“Монголын багш нарын 59 дэх өдөр”-ийн угтан багш нарын спортын тэмцээн, шилдэг тэргүүний багш нарыг шалгаруулах үйл ажиллагаа, баярын хурал, хүндэтгэлийн концерт зэрэг урлаг, спорт, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх 4 үйл ажиллагааг хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан. 2024-2025 оны хичээлийн жилд ажил мэргэжлийн ур чадвараараа манлайлсан 21 багшийг шалгаруулж мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.	100%	
					Хэсгийн дүн	60.0	55.0			
2.СОЁЛ, УРЛАГ										
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа : 5.2.1.Нийгмийн салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг сайжруулж, хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлтийг оновчтой болгоно.										
11	5.2.1.1	Соёлын салбарын хүний нөөцийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хувь	-	Бодлогын баримт бичиг боловсруулсан байна.	-	-	Соёлын салбарын хүний нөөцийн бодлогын баримт бичгийн боловсруулж дууссан бөгөөд 2026 оноос хэрэгжилтийг хангахаар төлөвлөж байна.	100%	
12	5.2.1.2	Орон нутагт дутагдалтай байгаа хормейстер, концертмейстер балетмейстер, найруулагч мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх	Дутагдалтай хүний нөөцийн бүрдүүлэлтийн хувь	-	75%	9.0	-	Орон нутагт дутагдалтай байгаа хормейстер, концертмейстер, балетмейстер найруулагч мэргэжлээр суралцахад орон нутгаас дэмжлэг үзүүлэх талаар салбарын байгууллагууд болон албан хаагчдад мэдээлэл хүргэж ажилласан. Тайлант онд дээрх мэргэжлээр суралцах хүсэлт гаргасан албан хаагч байхгүй байсан тул хормейстер, концертмейстер, балетмейстер, найруулагч мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, цаашид орон нутагтаа ажиллуулах зорилгоор СУИС-тай хамтран ажиллахаар төлөвлөж байна. Мөн “Уран эгшиг” сургуулийн төгсөх ангийн сурагчдад дээрх чиглэлээр суралцсан тохиолдолд төлбөрийн дэмжлэг үзүүлэхэ талаар мэдээлэл өгч, 1 сурагчийн ар гэрийнхэнтэй уулзаж, санал солилцсон.	0%	
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа : 5.2.2.Нийгмийн салбарын гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийн сургалт, хөгжлийг бодит хэрэгцээнд тулгуурлан дэмжиж, албан хаагчдын ажлын гүйцэтгэл бүтээмжийг дээшлүүлж, судлаач албан хаагчдыг бэлтгэнэ.										
13	5.2.2.1	Соёлын салбарын албан хаагчдын боловсролын зэргийг ахиулах, ахисан түвшиний сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх	Магистрын зэрэгтэй албан хаагчин эзлэх хувь (Төрийн байгууллагын ажилтнууд)	12.5 %	-	-	-	Тайлант онд тус салбарын албан хаагчдаас магистрын сургалтад хамрагдсан албан хаагч байхгүй байна.Төрийн захиргааны албан хаагчдаас 1 албан хаагчийг Удирдлагын академийн “Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт”-д хамрагдсан. Мөн соёлын салбарын 3 албан хаагч СУИС-д хувийн зардлаар эчнээгээр суралцсан бөгөөд албан хаагчдад боловсролоо дээшлүүлэхэд цалинтай чөлөө олгож байгууллагаас дэмжлэг үзүүлсэн. Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан.	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	
14	5.2.2.2	Соёлын байгууллагын албан хаагчдыг урт богино хугацааны мэргэшүүлэх сургалтад хамруулах	Тухайн жилд хамрагдвал зохих албан хаагчийн хувь (Төрийн байгууллагын ажилтнууд)	14.1%	40%	25.0	23.2	Тайлант хугацаанд соёлын байгууллагуудын албан хаагчдыг богино хугацааны мэргэшүүлэх 4, арга зүйн 2, нийт 6 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 116 албан хаагчийг хамруулсан. Үүнээс мэргэшүүлэх сургалтад 56 албан хаагч буюу нийт албан хаагчийн 44.0%-ийг хамруулсан. Үүнд: 1.Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас Монгол Улсын Үндэсний номын сантай хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын сургууль, соёлын төвүүд, аймгийн Нийтийн номын сангийн номын санчдад	100%	

зориулсан ахисан түвшний 2 өдрийн танхимын сургалтыг зохион байгуулж, 60 гаруй номын санч хамрагдсан. Тус сургалтыг Үндэсний номын сангийн Мэдээлэл, арга зүй, эрдэм шинжилгээний хэлтсийн дарга, доктор Т.Хайдав, Үндэсний номын сангийн цахим хөгжүүлэлт, сүлжээний инженер М.Ариунболд, НББСХ-ийн дарга Г.Гүнжинлхам, ЦШМТА-ны дарга Б.Бат-Эрдэнэ, МАЗЭШ-ийн ном зүйч Г.Баяртуяа, инженер ЦШМТА-ны инженер Б.Мөрөн нар удирдан “Номын сангийн үйлчилгээний хүртээмж”, Номын сангийн салбарын эрх зүйн орчин, “Алслагдсан болон номын санд ирж амжихгүй байгаа иргэдэд зориулсан үйлчилгээ”, “Иргэд, уншигчдын оролцоог дэмжих хөтөлбөрүүд” “Цахим номын сангийн нэгдсэн системийн нэвтрүүлэлт”, “Номын сангийн бүртгэлүүдийг цахимжуулах хэрэгцээ шаардлага”, Номын сангийн “Нэг бүрчилсэн болон өдөр тутмын бүртгэлийн цахимжуулалт”, номын сангуудад шинээр нэвтэрч буй “KoHa” нэгдсэн цахим систем, “Цахим номын сан, цахим ур чадвар”, “Цахим орчин дахь ном зүйн үйлчилгээ” зэрэг агуулгаар явуулж, сургалтад хамрагдсан номын санчдад “KoHa” программын эрхийг нээж өгсөн. Уг сургалтад хөтөлбөрийн зардлаас 5.0 сая төгрөг зарцуулсан.

2. Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас орон нутгийн музейн албан хаагчдын саналд тулгуурлан Чингис хаан Үндэсний музейтэй хамтран “Музейн үйл ажиллагааны арга зүй” сэдэвт онол практик хосолсон сургалтыг зохион байгуулж, сургалтад аймгийн Музей, соёлын төвийн орон нутаг судлах танхим, “Эрдэнэт үйлдвэр”ТӨҮГ-ын дэргэдэх музейн нийт 14 албан хаагчийг хамруулсан. Сургалтад хамрагдсан ажилтнуудад “Музейн олон улсын стандарт, дүрэм журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрхэн нэвтрүүлэх”, “Соёлын бүтээлч үйлдвэрлэлээр дамжуулан музейг ашиглах боломж”, “Үзмэрийн бүртгэлийн нэгдсэн систем, орчин үеийн техник, тоног төхөөрөмж ашиглах, хадгалалт хамгаалалтын горим” зэрэг практик мэдлэг, чадварыг олгосон байна. Сургалтын хүрээнд Чингис хаан үндэсний музейн ерөнхий менежер, Ph.D Д.Эрдмаа-“Ерөнхий танилцуулга, музейн үзмэрт суурилан ЕБС-ийн хичээлийг интеграцчилах арга зүй” Эрдэм шинжилгээний ажилтан, куратор Ж.Эрдэнэ-“Музейн үзмэрийн судалгааны арга зүй”, Бүртгэл мэдээллийн сангийн ахлах Ш.Эрдэнэцэцэг- “Музейн бүртгэл баримтжуулалтын арга зүй”, Ахлах сан хөмрөгч Б.Эрдэнэцэцэг- “Музейн хадгалалт, хамгаалалтын зохистой орчин бүрдүүлэх арга зүй”, Бүртгэл мэдээллийн санч С.Буянжаргал- “Музейн үзмэрийн хаяг тайлбар бичих арга зүй” сэдвүүдээр лекц, илтгэл тавьсан байна. Уг сургалтад хөтөлбөрийн зардлаас 2.8 сая төгрөг зарцуулсан байна.

3. Тайлант хугацаанд СУИС-тай хамтран аймгийн Хүүхэд залуучуудын театрын уран бүтээлчид, жүжигчдэд зориулсан “Физикл жүжигт ажиллах жүжигчний ажиллагаа” сэдэвт 12 цагийн сургалтыг зохион байгуулж, 12 жүжигчин хамрагдсан. Сургалтад хамрагдсан жүжигчдийн сургалтаар эзэмшсэн мэдлэг чадварыг үнэлэх зорилгоор “Эдип хаан” жүжгээр шалгалт авч, сертификат олгосон. Тус сургалтын хүрээнд СУИС-ийн багш У.Дэлгэрбуян “Физикл жүжгийн зохиол бичих арга зүй”, М.Ариунжолоо “Жүжиглэх ур чадвар”, Б.Болдхүү “Тайзны хөдөлгөөн” зэрэг хичээлүүдийг заасан бөгөөд сургалтын зардалд хөтөлбөрөөс 5.0 сая төгрөг зарцуулсан байна.

4.Хөтөлбөрийн хүрээнд "Хичээнгүй үндэс" ТББ-тай хамтран "Хувь хүний хөгжил, манлайлал" сэдэвт 1 өдрийн сургалтыг зохион байгуулж, соёл, урлагийн байгууллагын 99 албан хаагчийг

								<p>хамруулсан байна. Сургалтаар албан хаагчдад харилцааны ур чадвар, ёс зүй, хүний хөгжил, манлайллын талаарх мэдлэг ойлголт, зөвлөгөөг өгсөн. Сургалтын зардалд хөтөлбөрөөс 4.4 сая төгрөг зарцуулсан байна.</p> <p>5.Соёл, урлагийн салбарын албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх зорилгоор дизайнер, аниматор А.Ариунболдтой хамтран 2 өдрийн нийт 6 цагийн танхимын сургалтыг зохион байгуулж, соёл, урлагийн 9 байгууллагын 22 албан хаагчийг хамруулж, цахим контент бүтээх ур чадвар олгосон бөгөөд сургалтын зардалд 3.0 сая төгрөг зарцуулсан.</p> <p>6.Улсын Хүүхэлдэйн театрын жүжигчин, дуу оруулагч Ж.Болор-Эрдэнэтэй хамтран мэргэжлийн хөтөлгөч бэлтгэх 3 цагийн лекц, 5 цагийн практик сургалтыг зохион байгуулж, соёл, урлагийн байгууллагын 10 албан хаагчийг хамруулсан. Сургалтаар тайзнаас ярих урлагийн анхан шатны мэдэгдэхүүн, ойлголтыг олгосон. Сургалтын зардалд 3.0 сая төгрөг зарцуулсан.</p>	
15	5.2.2.3	Соёл, урлагийн байгууллагын ажилтнуудыг гадаад, дотоодод туршлага судлуулах	Гадаадад туршлага судалсан албан хаагчийн тоо	23	25 албан хаагч	11.0	16.8	<p>Тайлант хугацаанд соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын салбарын 10 байгууллагын 11 албан хаагчдын Өмнөговь, Дундговь, Дархан-Уул аймгуудын туршлага судлах арга хэмжээнд 11.8 сая, аймгийн Нийтийн номын сан болон ерөнхий боловсролын сургуулиудын номын санч 20 албан хаагчийн БНХАУ-ын Бээжин хотын номын сантай танилцах, туршлага судлах үйл ажиллагаанд 5.0 сая төгрөгийн дэмжлэгийг хөтөлбөрийн хүрээнд олгосон. Мөн "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Соёл, урлагийн цогцолборын "Эрдэнэт чуулга"-ын 10 уран бүтээлчийг БНСУ-ын Жезү хотод зохион байгуулагдсан "Тамна" олон улсын ардын урлагийн наадамд оролцох зардалд орон нутгийн төсвөөс 25.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.</p>	100%
16	5.2.2.4	Бүсийн хэмжээнд соёл, урлагийн байгууллагуудын туршлага, солилцох уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулах	Зөвлөгөөн, хэлэлцүүлгээс гарсан шийдвэрийн хэрэгжилтийн хувь	-	100%	5.0	-	<p>Тайлант хугацаанд Соёлын яамтай хамтран хойд бүсийн аймгуудын соёл урлаг, аялал жуулчлал, залуучууд, спортын салбарын удирдах ажилтны анхдугаар зөвлөгөөн зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд Орхон, Булган, Хөвсгөл аймгуудын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын газар, Биеийн тамир спортын газрын дарга, холбогдох мэргэжилтэн, нийт 100 гаруй албан хаагч оролцож, хойд бүсийн хэмжээнд соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын стратеги, соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын чиглэлээр хэрэгжүүлэх 2025-2028 оны стратеги төлөвлөгөө, төлөвлөлт, хэрэгжүүлэх арга хэмжээг хэлэлцсэн. Зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 84%-ийн биелэлттэй байна.</p>	84.0%
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа : 5.2.3.Нийгмийн салбарын хүний нөөцийн сэтгэл ханамжийг дээшлүүлж, албан хаагчдын амжилтыг үнэлж, урамшуулна.									
17	5.2.3.1	"Монголын Соёл, урлагийн ажилтны өдөр"-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, албан хаагчдыг урамшуулах	Албан хаагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	4	-	-	<p>Соёл урлагийн ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд шилдэг байгууллага, шилдэг уран бүтээлч, шилдэг соёлын ажилтан, шилдэг үйлчилгээний ажилтан шалгаруулах үйл ажиллагаа, баярын хурал, хүндэтгэлийн концерт, хөгжөөнт буухиа тэмцээн зэрэг 4 арга хэмжээг зохион байгуулж 11 байгууллагын 150 гаруй албан хаагчийг хамруулсан. Мөн тайлант хугацаанд аймгийн нийт соёлын байгууллагуудын дунд "Соёлынхон" спортын 3 төрөлт нөхөрсөг тэмцээнийг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 2.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 11 байгууллагын 200 гаруй албан хаагч хамрагдсан байна.</p>	100%
						Хэсгийн дүн	50.0	40.0	

3.ЭРҮҮЛ МЭНД

Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа : 5.2.1.Нийгмийн салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг сайжруулж, хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлтийг оновчтой болгоно.

18	5.2.1.1	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлнэ.	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хувь	89,5%	90%	-	-	<p>2025 оны жилийн эцсийн байдлаар Эрүүл мэндийн салбарт нийт 2069 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> • Их эмч – 479, • Сувилагч – 507 байна. <p>Орхон аймгийн Эрүүл мэндийн салбарын 2025–2030 оны хүний нөөцийн төлөвлөлтийг 2 арга хэмжээ, 8 шалгуур үзүүлэлттэйгээр батлуулж, хэрэгжилт 90.5% байна.</p> <p>Тодорхой үзүүлэлтээр:</p> <ul style="list-style-type: none"> • Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн – 72.5%, • Нэн шаардлагатай мэргэжил эзэмшсэн эмч – 47.9%, • Хүний нөөцийн бүрдүүлэлт – 81%, • Төлөвлөгөөний хэрэгжилт – 90.5% байна. <p>Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарт Улаанбаатар хот болон бусад аймгаас шилжин ирсэн 25 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байраар хангаж ажиллуулсан.</p>	100%
19	5.2.1.2	Анагаах ухааны мэргэжлийн их, дээд сургуулиудтай хүний нөөцийг бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллах,орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх	Ажилд орсон шинэ төгсөгчийн тоо	5	5	-	-	<p>Тайлант хугацаанд улсын төсвийн болон хувийн зардлаар үндсэн мэргэшил, төрөлжсөн мэргэшил болон мэргэжил дээшлүүлэх сургалтад нийт 35 эмч, эмнэлгийн мэргэжилтэн суралцсанаас 22 нь улсын төсвийн санхүүжилтээр суралцсан байна.</p> <p>Орон нутагт нэн шаардлагатай дараах 6 мэргэшлээр 9 эмч, 9 сувилагчийг сургасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Өвдөгний үений мэс засал судлал • Эмэгтэйчүүдийн хавдар судлал • Ходоод, нарийн гэдэсний хавдрын мэс засал судлал • Хөх, улаан хоолойн хавдрын мэс засал судлал • Эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал судлал, эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал судлал • Хавдрын сувилагч, хөнгөвчлөх эмчилгээний сувилагч <p>Эдгээр сургалтад хамрагдсан эмч, сувилагч нар нь орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн мэргэжил эзэмшсэн байна.</p> <p>2025 онд 9 сувилагч шинэ сувилагчийн 3 сарын сургалтад хамрагдаж, БОЭТ-2, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад-2, сум-1, өрхийн эрүүл мэндийн төвд -4 сувилагч шинээр ажилд орсон байна</p>	100%
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа : 5.2.2.Нийгмийн салбарын гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийн сургалт, хөгжлийг бодит хэрэгцээнд тулгуурлан дэмжиж, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, бүтээмжийг дээшлүүлж, судлаач албан хаагчдыг бэлтгэнэ.									
20	5.2.2.1	Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтан бэлтгэх, мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх давтан сургалтад хамруулах	Сургалтад хамрагдсан хүний тоо	-	5	10.0	10.0	<p>Тайлант хугацаанд ажлын байрны болон алсын зайн сургалтад 543 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 0,2%-иар өссөн үзүүлэлттэй байна. Магистр болон докторын сургалтад 14 эмч, эмнэлгийн мэргэжилтэн суралцаж байгаагаас 5 мэргэжилтэн нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр магистрын сургалтад шинээр элсэн суралцаж байна.</p>	100%
21	5.2.2.2	“Яаралтай тусламжийн сувилахуй” төгсөлтийн дараах сургалтад ӨЭМТ, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын сувилагч нарыг сургаж хариуцлагын гэрээ байгуулж, дэмжлэг үзүүлэх	Сургалтад хамрагдсан сувилагчийн тоо	2	-	-	-	<p>БОЭТ-ийн төгсөлтийн дараах сургалтын байгууллагын 7 дахь жилийн сургалтад яаралтай тусламжийн сувилахуйн чиглэлээр 6, эрчимт эмчилгээний сувилахуйн чиглэлээр 1 нийт 7 сувилагч суралцаж байна.</p>	100%
22	5.2.2.3	Хавдрын үндэсний багтай хамтран ажиллах	Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо	20	200	-	-	<p>Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг түшиглэн орон нутгийн 350.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Соотон чоно ХХК тендерт шалгарч, тус төвийн их засварын ажлыг бүрэн гүйцэтгэсэн.</p>	100%

								<p>Үүний хүрээнд 2025 онд Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт, сэргийлэлтийн төвийг өргөтгөн, нийт 223.4 м² талбайд үйлчлүүлэгчийн хүлээлгийн хэсэг, хавдрын амбулаторийн үзлэг, хавдрын бүртгэл, эхо оношилгоо, мэс заслын эмчийн үзлэг, хими болон бай эмчилгээний өрөөнүүдийг шинээр байгуулж, үйлчлүүлэгчдэд ээлтэй, тав тухтай орчныг бүрдүүлсэн.</p> <p>Эмгэг судлалын оношилгоо, гистологи, эсийн шинжилгээний үйл ажиллагааг сайжруулах зорилгоор улсын төсвөөс 800.0 сая төгрөгийн өртөг бүхий иж бүрэн тоног төхөөрөмж, хэрэгслийг нийлүүлж, суурилуулснаар оношилгооны чадавх нэмэгдсэн.</p> <p>Тайлант хугацаанд тус төвөөр нийт 1092 үзлэг хийгдсэнээс:</p> <ul style="list-style-type: none"> • Өвчний зовиурын улмаас эмнэлэгт хандан хавдар оношлогдсон – 113 хүн (78.4%), • Эрт илрүүлгээр хавдар илэрсэн – 31 хүн (21.5%), • Үүнээс Хавдрын төвөөр оношлогдсон – 5 хүн, • Диспансерын хяналтад 1,540 иргэн байна. <p>Нийт хавдрын:</p> <ul style="list-style-type: none"> • 44.4 хувь нь эрт үед, • 55.5 хувь нь хожуу үед оношлогдсон байна. <p>Мөн тайлант хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> • Хими эмчилгээнд 129 хүн, • Бай эмчилгээнд 55 хүн тус тус хамрагдсан. <p>Тайлант хугацаанд хорт хавдрын 164 шинэ тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 15.4 промилл болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.3 промиллоор өссөн үзүүлэлт юм.</p> <p>Шинээр бүртгэгдсэн хорт хавдрын бүтцэд:</p> <ul style="list-style-type: none"> • Элэгний хавдар – 26.2%, • Ходоодны хавдар – 17.7%, • Умайн хүзүүний өмөн – 7.9%, • Нойр булчирхайн хорт хавдар – 6.7%, • Бусад хавдар – 41.5% тус тус эзэлж байна. <p>Үндэсний баг Орхон аймагт 2 удаа ажиллан ходоод, бүдүүн шулуун гэдэс, хөх, зүрх судас, хими эмчилгээ, элэг цөс, тархи мэдрэлийн чиглэлээр нийт 534 иргэнд үзлэг хийж, орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах онол, дадлагат сургалтад давхардсан тоогоор 125 хүнийг хамруулан, хамтарсан үзлэг оношилгоо, хагалгаа хийж чадавхжуулсан байна.</p> <p>Засгийн газрын 2025 оны 204 дүгээр тогтоолоор “Эрдэнэт медиал” төрөлжсөн эмнэлгийг Хавдрын үндэсний төв эмнэлгийн салбар эмнэлэг болгон хөгжүүлэх шийдвэр гарч, бүсийн хэмжээнд хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрөл, хүлээгдлийг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдээд байна.</p>	
23	5.2.2.4	Орон нутагт нэн шаардлагатай эмч, сувилагч нарыг багаар нь гадаад болон дотоодод урт болон богино хугацааны сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх	Хүний нөөцийн бүрдүүлэлтийн хувь	53	55	66.0	66.0	<p>БНСУ-д зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүсийн өрхийн эмч нарын чуулганд Орхон аймгийн 8 эрүүл мэндийн төвийн 11 эмч оролцож, Энэтхэгийн “Мах Хийлткэйр” групптэй хамтран 13 өвчтөнд зөвлөгөө өгч, 15 эмчид хавдрын менежментийн сургалт зохион байгуулсан.</p> <p>Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс Япон, БНХАУ, Филиппин, Узбекистан, БНСУ зэрэг улс орнуудад эх барих, нярайн эмчилгээ, мэс засал, удирдлага, хараа зүй, бөөр, мэдрэл зэрэг чиглэлээр 11 эмч олон улсын сургалт, семинаруудад хамрагдаж, онол, дадлагыг хослуулан мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн.</p> <p>Мөн Австри, БНСУ-д нийт 5 мэргэжилтэн туршлага судалсан байна. БНСУ-д өвдөгний үений дурангийн мэс заслаар мэргэшсэн эмч орон нутагт тус хагалгааг нутагшуулж байна.</p>	0%
24	5.2.2.5	Эрүүл мэндийн салбарт шинэ төрлийн эмчилгээ, технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	Шинээр нэвтрүүлсэн эмчилгээ, үйлчилгээний тоо	32	-	5.0	5.0	<p>Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад тусламж, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, хавдрын маркер, триглицерид, липид, иммунологийн шинжилгээ (CRP, TSH, витамин D), глюкозжсон гемоглобин зэрэг 5 төрлийн шинжилгээг хийж эхлээд байна.</p> <p>Эрдэнэт медиал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт:</p> <ul style="list-style-type: none"> • 2024 онд үйлдвэрлэгдсэн GE E6 өндөр нягтралтай 	100%

							<p>ургийн эхо аппаратаар жирэмсний 11 долоо хоногт ургийн гажгийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээг 237 иргэнд хийсэн.</p> <ul style="list-style-type: none"> • Дэлхийд тэргүүлэх “General Electric” компанийн MRI болон СТ аппаратаар тайлант хугацаанд 1,025 иргэнд дүрс оношилгооны үйлчилгээ үзүүлсэн. • Тархины судасны доплерийн төрөлжсөн мэргэшлийн сургалтад эмчийг хамруулж, 38 хүнд оношилгоо хийсэн. <p>Баян-Өндөр мед эмнэлэгт хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн “CerviCare AI” системийг нэвтрүүлэн:</p> <ul style="list-style-type: none"> • 476 хүнд үзлэг, шинжилгээ хийж, • 329 эрүүл иргэнд зөвлөгөө, мэдээлэл хүргэн, • Хавдрын урьдал үе шаттай 83 хүнийг илрүүлж, • 64 хүнийг эмчилгээнд хамруулсан. <p>RMC эмнэлэгтэй хамтарсан үргүйдлийн оношилгооны кабинетаар</p> <ul style="list-style-type: none"> • 64 хүнд оношилгоо хийж, • 9 хүнийг лавлагаа шатлалд илгээсэн байна. <p>Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд:</p> <ul style="list-style-type: none"> • Зүрхний титэм судсан дотуурх мэс засал – 201 хүн, • Тархины судасны оношилгоо, эмчилгээ – 28 хүн, • Элэгний хавдар бөглөх ажилбар – 26 хүн тус тус хийгдсэн. <p>Мөн амьсгалын хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 6 нярайд сурфактант эмчилгээ хийж, 83.3%-ийн үр дүн үзүүлсэн. Мухар олгойг дурангаар авах мэс заслыг нэвтрүүлж, 11 хүнд амжилттай хийсэн бөгөөд шээлгүүрийн дурангаар 5 хүнд шээлгүүр стент тавих, 2 хүнд чулуу авах хоёр үе шаттай хагалгааг гүйцэтгэсэн.</p> <p>Тайлант хугацаанд 757 нярай төрсөн бөгөөд эрт үеийн нэн шаардлагатай тусламж, нярайн тандалт, скрининг шинжилгээнд төрсөн нярай бүрийг 100% хамруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Түнхний үений эхо оношилгоо – 767 нярай, • Сонсголын скрининг – 754 нярай, • Нүдний угийн улаан рефлекс – 767 нярай, • Бодисын солилцооны 5 төрлийн эмгэг илрүүлэх шинжилгээ – 560 нярай тус тус хамрагдсан байна. 		
25	5.2.2.6	Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын ур чадвар, ёс зүй харьцаа хандлагыг сайжруулах олон талт арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	2	4.0	4.0	<p>Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны тогтоолын хүрээнд Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, эрүүл мэндийн байгууллагуудын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороод, мөн Сум, ӨЭМТ-үүдэд ёс зүйн багууд байгуулагдан, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ёс зүйн алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нийт 3 удаа зохион байгуулан ажилласан байна.</p> <p>Тайлант хугацаанд Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо нийт 4 удаа хуралдаж, 3 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 95.5 хувьтай байна.</p> <p>АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуультай хамтран “Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүй” сэдэвт кредиттэй сургалтад 18 эрүүл мэндийн байгууллагын 186 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, ёс зүйн хууль тогтоомжийн талаарх мэдлэг 18 хувиар нэмэгдсэн байна.</p> <p>Мөн Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос зохион байгуулсан “Эмнэлгийн</p>	100%

								<p>мэргэжилтний ёс зүй, хариуцлага” сэдэвт үндэсний хэлэлцүүлэгт ёс зүйн салбар хорооны 4 гишүүн хамрагдан, чадавхажсан. Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан Нээлттэй хаалганы өдөр-ийн хүрээнд “Эрүүл мэндийн ажилтны ёс зүйн дүрэм”, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхэд анхаарах зүйлс зэрэг агуулгатай тараах материалыг бэлтгэн, эмнэлгийн мэргэжилтэн болон иргэдэд нийт 500 ширхгийг тарааж, мэдээлэл, зөвлөгөө хүргэсэн.</p> <p>Тайлант хугацаанд Эрүүл мэндийн газрын албан хаагчдын ажлын байранд тавигдах журмыг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Түүнчлэн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ” хэлэлцүүлэг, “Бүсчилсэн хөгжил – Төрийн албаны манлайлал” бүсийн зөвлөгөөнд ёс зүйн хорооны гишүүд болон албан хаагчид хамрагдан, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.</p>		
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа :5.2.3.Нийгмийн салбарын хүний нөөцийн сэтгэл ханамжийг дээшлүүлж,албан хаагчдын амжилтыг үнэлж, урамшуулна.										
26	5.2.3.1	Эрүүл мэндийн салбарын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, гарсан санал санаачилгыг дэмжин ажиллах.	<p>Зөвлөлдөх уулзалтад хамрагдсан эмч, мэргэжилтнүүдийн тоо</p> <p>Гарсан санал, санаачлагад дэмжлэг үзүүлсэн ажлын тоо</p>	40	60		10.0	10.0	<p>Эрүүл мэндийн салбарын зөвлөлдөх уулзалтыг томуу, томуу төст өвчин, улаан бурхан өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр уулзалт, хурлыг нийт 4 удаа зохион байгуулж, гарсан зөвлөмж шийдвэрийн хэрэгжилт 95.6 хувьтай байна. Энэ хүрээнд Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/49 дүгээр тушаалаар нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг хангах, шуурхай удирдлагын баг томилогдон томуу томуу төст өвчин, улаан бурхан өвчний дэгдэлтийн үед Тохиолдол удирдлагын тогтолцоонд 4 удаа шуурхай шилжин эрсдэл харилцаа холбоог идэвхжүүлэн, хариу арга хэмжээг авч ажилласан байна.</p> <p>Мөн тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын байгууллагуудын давхардсан тоогоор 312 удирдлагуудын шуурхайг танхимаар 12, Эрүүл мэндийн газрын албан хаагчдын шуурхай танхимаар 32 удаа хуралдаж, мэдээллээр ханган, үүрэг даалгавар өгч хариуцлагажуулан ажилласан. Монголын Яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран Хойд бүсийн хэмжээнд яаралтай тусламжийн үйлчилгээг сайжруулах зорилгоор уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөөд байна.</p>	97.8%
27	5.2.3.2	Эрүүл мэндийн салбарын тэмдэглэлт өдрүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	5	3		25.0	25.0	<p>2025 онд эрүүл мэндийн салбарын тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан болон салбарын хэмжээнд 316 удаагийн сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, нийт 5 арга хэмжээнд давхардсан тоогоор 20,098 иргэн болон эрүүл мэндийн салбарын ажилтныг хамруулсан байна. Байгууллагын цахим хуудсанд эрүүл мэндийн чиглэлээр 789 төрлийн мэдээлэл нийтэлж, нийт 1,013,184 хандалт авсан байна.</p> <p>Эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд болон салбарын хэмжээнд зохион байгуулсан сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар нийт 133 төрлийн видео зөвлөмж, мэдээлэл, сурвалжилга, 55 төрлийн анонс, өргөмжлөл, сертификат, гарын авлага, 81 удаагийн фото зурган мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж ажилласан.</p> <p>Мөн орон нутгийн 4 телевизээр 9 удаагийн мэдээ, FM радиогоор 2 удаагийн мэдээ, сурвалжилгыг бэлтгэн хүргэж, орон нутгийн сонинтой хамтран 7 удаа шинэ мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд түгээж ажилласан байна.</p>	100%
28	5.2.3.3	Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын ур	Зохион	1	2		4.0	4.0	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн	100%

								<p>дасгалжуулагч тэнцэж, сертификат гардан авсан.</p> <p>-Монголын волейболын холбоотой хамтран “Волейболын шүүгч бэлтгэх” онол, практик хосолсон анхан шатны сургалтад Орхон аймгаас 9 биеийн тамирын багш хамрагдаж, батламжаа гардан авсан.</p> <p>Шүүгчийн анхан шатны сургалтад хамрагдсан биеийн тамирын багш, дасгалжуулагч нар нь аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг шүүх эрхтэй болсон.</p> <p>Нийт 42 биеийн тамирын багшийг сургалтад хамруулж 39 багш шүүгчээр ажиллах эрхтэй болсон.</p>	
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа : 5.2.2.Нийгмийн салбарын гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийн сургалт, хөгжлийг бодит хэрэгцээнд тулгуурлан дэмжиж, албан хаагчдын ажлын гүйцэтгэл,бүтээмжийг дээшлүүлж, судлаач албан хаагчдыг бэлтгэнэ.									
31	5.2.2.1	Биеийн тамир, спортын салбарын албан хаагчдын дунд олон талт сургалт зохион байгуулах, оролцуулах	Зохион байгуулсан сургалтын тоо /тухайн жилдээ/	1	40 албан хаагч, дасгалжуулагч	5.0	-	<p>Биеийн тамир спортын салбарын хэмжээнд ажлын байранд мэргэшүүлэх, дасгалжуулагч, шүүгч бэлтгэх, арга зүйчийг чадавхжуулах 19 удаагийн сургалтад давхардсан тоогоор 210 албан хаагч, биеийн тамирын багш, дасгалжуулагч нарыг хамруулсан.Сургалтыг зохион байгуулах, оролцуулахад орон нутгийн төсвийн 29,0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.Үүнд:</p> <p>-Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан 4 удаагийн сургалт арга хэмжээнд давхардсан тоогоор 39 албан хаагч, биеийн тамирын арга зүйч нар,</p> <p>-Хөл бөмбөг сагсан бөмбөгийн шүүгч, зэрэглэлтэй дасгалжуулагч бэлтгэх 3 удаагийн сургалтад 65 биеийн тамирын багш дасгалжуулагч нар,</p> <p>-Спортын анагаах ухаан эрдэм шинжилгээний төвөөс зохион байгуулсан сургалтад 56 биеийн тамирын багш арга зүйч дасгалжуулагч нар,</p> <p>-Төрийн албаны зөвлөл Удирдлагын академиас зохион байгуулсан сургалтад 2 албан хаагч,</p> <p>-Бусад байгууллагаас зохион байгуулсан төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт шинжилгээ үнэлгээ, архив, төсөв санхүүгийн чиглэлээр 10 удаагийн сургалтад 48 албан хаагчдыг тус тус хамруулсан.</p> <p>Спорт холбоодыг чадавхжуулах чиглэлээр менежмент маркетингийн мэргэшсэн багш нараар сургалт хийлгэхээр гэрээ байгуулсан боловч Засгийн газрын шийдвэр, төрийн сангийн үйл ажиллагаанаас шалтгаалж аймгийн Засаг даргын 2025 оны А/811 дүгээр захирамжаар батлагдсан 5.0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулах боломжгүй болсон.</p>	100%
32	5.2.2.2	Дасгалжуулагч бэлтгэх сургалтад багш нарыг хамруулах	Зэрэглэлтэй дасгалжуулагчдын тоо /тухайн жилдээ/	11	10 дасгалжуулагч	5.0	10.0	<p>Монголын сагсан бөмбөгийн дасгалжуулагчдын холбооноос Улаанбаатар хотод зохион байгуулсан сагсан бөмбөгийн зэрэглэл олгох 5 үе шаттай сургалтад Орхон аймгаас 12 биеийн тамирын багш нарыг хамруулахаар гэрээ байгуулж, сургалтын төлбөрт 5,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Сургалт 2025 оны 10 сарын 27-ний өдрөөс эхэлсэн бөгөөд 2026 оны 02 сарын 23-ны өдөр хүртэл явагдаж дуусна. Сургалтад аймгийн Засаг даргын 2025 оны А/811 дүгээр захирамжаар батлагдсан 5,0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.</p> <p>Монголын хөл бөмбөгийн холбооны техникийн зөвлөлтэй хамтран хөл бөмбөгийн дасгалжуулагч бэлтгэх анхан шатны “Грассрүүтс” онол, практикийн сургалтыг Орхон аймагт 2025 оны 12 сарын 11-ний өдрөөс 12 сарын 12-ны өдрүүдэд ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн спорт зааланд зохион байгуулсан. Сургалтад 20 биеийн тамирын багш, дасгалжуулагч хамрагдаж сертификат авсанаар С зэрэглэлийн шүүгч, дасгалжуулагч бэлтгэх сургалтад суралцах эрхээ авсан. Сургалтад 5,0 сая төгрөг зарцуулсан.</p>	100%
33	5.2.2.3	Салбарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх гэрээт ажилтныг ажиллуулах	Гэрээт ажилтны тоо	-	-	8.5	8.5	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны харьяа “Спортын анагаах ухаан, эрдэм	0%

			/тухайн жилдээ/					шинжилгээний төв"-тэй хамтран "Идэвхтэй хөдөлгөөн ба ажлын байрны дасгал, Спортын гэмтлийн үед авах арга хэмжээ, Биеийн тамир, спортоор хичээллэгсэд өгөх зөвлөмж" сэдвүүдээр сургалтуудыг аймагтаа 2025 оны 11 дүгээр сарын 12-16-ны өдрүүдэд зохион байгуулж, 56 биеийн тамирын багш, арга зүйч, дасгалжуулагч нарыг хамруулан дасгал хөдөлгөөн хийх үед анхаарах зөвлөмж гарын авлагыг өгсөн. Мөн өсвөрийн шигшээ багийн тамирчид болон төрийн албан хаагчид, иргэд 300 гаруй хүний бие бялдрын түвшнийг автомат төхөөрөмжөөр тодорхойлж, мэргэжлийн эмч, эрдэм шинжилгээний ажилтнуудаар зөвлөмжийг өгүүлж ажилласан.Сургалт арга хэмжээнд аймгийн Засаг даргын 2025 оны А/811 дүгээр захирамжаар батлагдсан 8,5 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан. Гэрээт ажилтан ажиллуулаагүй, байгууллагуудтай хамтарч ажилласан.	
34	5.2.2.4	Биеийн тамир, спортын салбарын албан хаагчдыг гадаадад туршлага судлуулах;	Туршлага судлуулах үйл ажиллагаанд хамрагдсан албан хаагчийн тоо/тухайн жилдээ/	2	-	-		Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан.	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй
35	5.2.2.5	Хойд бүсийн биеийн тамир, спортын байгууллагуудын дунд зөвлөгөөн зохион байгуулах, оролцох;	Зөвлөгөөнд хамрагдсан албан хаагчдын тоо /тухайн жилдээ/	-	-	-		Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан.	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа : 5.2.3.Нийгмийн салбарын хүний нөөцийн сэтгэл ханамжийг дээшлүүлж, албан хаагчдын амжилтыг үнэлж, урамшуулна.									
36	5.2.3.1	Жил бүр "Тамирчдын баярын өдөр"-ийг тэмдэглэж дасгалжуулагч тамирчдыг алдаршуулж урамшуулах	Шагналд хамрагдсан дасгалжуулагчдын тоо	-	-	-		Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан.	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй
				Хэсгийн дүн	28.5	23.5			
5.ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛАЛ									
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа : 5.2.1.Нийгмийн салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг сайжруулж, хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлтийг оновчтой болгоно.									
37	5.2.1.1	Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын хүний нөөцийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангасан байх	-		Бодлогын баримт бичиг боловсруулсан байна.	-	Орон тоо 9.0 хувиар бууруулах шийдвэртэй холбогдуулан ХХҮГ 52 орон тоог 47, НДГ нь 40 орон тоог 36 болгон ажилласан бол, ХГБХХГ нь 43 орон тоог 55 (Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан баг бүрт ажиллах шийдвэртэй холбогдуулан) болгон шинэ бүтэц, орон тооны дагуу дотоод зохион байгуулалт хийж ажилласан. Хөдөлмөрийн нөхцөл, бодит ачаалал, ажлын давхцал хийдэл, байгууллагын чиг үүрэг алдагдуулахгүй байх, дотоод зөрчил маргаан санал гомдолгүй, хүний эрхийн зөрчилгүй байхад анхаарч, албан тушаалын тодорхойлолт, чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдын цалин хөлсийг тогтоон нийгмийн баталгааг ханган ажиллаж байна. Байгууллагын хүний нөөцийн чадвар чадавхыг тандах, гадаад дотоод хүчин зүйл, давуу болон сул талаа тодорхойлох олон талт судалгаануудыг хийж тус газрууд хүний нөөцийн бодлогоо боловсруулан ажиллаж байна.	100%
38	5.2.1.2	Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын хүний нөөцийн бүрдүүлэлтийг хийх	Хүний нөөцийн бүрдүүлэлт хийгдсэн тоо	17	3	-		Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын орон тооны дээд хязгаар, зохион байгуулалтын бүтэц"-ийг 47 орон тоотойгоор баталсан. Энэ бүтцийн дагуу төрийн жинхэнэ албан тушаалд 37 мэргэжилтэн, төрийн үйлчилгээний албан тушаалд 10 ажилчинтай үйл ажиллагаагаа явуулж байна. Жаргалант сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд шилжүүлэн ажиллуулах, 2 мэргэжилтнийг жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд	100%

								асрах чөлөөтэй байх хугацаанд төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн 2 иргэнийг Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан сумын мэргэжилтний албан үүргийг түр орон гүйцэтгүүлж байна. Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр дотоод хөдөлгөөн хийж 4 албан хаагч өөр албан тушаалд томилогдсон. Нийгмийн даатгалын газар УИХ-ын 2025 оны 48 дугаар тогтоолын орон тоог 9.0%-иар бууруулах шийдвэрийн дагуу орон тоог 4-өөр цөөлж, Нэг цэгийн үйлчилгээ цахим мэдээллийн тасгийг татан буулгасан. Батлагдсан орон тоо 36 байгаагаас гүйцэтгэлээр 35 албан хаагч ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар 2 сул орон тоо гарч, Төрийн албаны тухай хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулж төрийн албаны нөөцөөс нөхсөн бол, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтний орон тоог төрийн өөр байгууллагаас шилжүүлэн авч ажиллуулах журмын дагуу нөхсөн. Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газарт ажлын байранд шилжүүлэн ажиллах журмын дагуу 3 албан хаагч шилжин ажиллаж, шинээр 24 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг ажилд авч, тэдний нийгмийн баталгааг бүрэн хангаж ажиллалаа.	
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа :5.2.2.Нийгмийн салбарын гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлж,хүний нөөцийн сургалт, хөгжлийг бодит хэрэгцээнд тулгуурлан дэмжиж,албан хаагчдын ажлын гүйцэтгэл, бүтээмжийг дээшлүүлж, судлаач албан хаагчдыг бэлтгэнэ.									
39	5.2.2.1	Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр “Шинэ залуу албан хаагч” ментор арга хэмжээг хэрэгжүүлэх.	Арга хэмжээнд хамрагдсан албан хаагчдын тоо	-	72	10.0	9.8	Нийгмийн даатгалын газрын хэмжээнд хэрэгжүүлж, үр дүнгээ өгсөн “Сэтгэл зүйн дархлаатай хамт олон” төслийн хүрээнд нийгмийн салбарын хэмжээнд хэрэгжүүлж байна. Салбарын байгууллага бүр дотооддоо хэлэлцэж, туршлага, ур чадвар, ажлын гүйцэтгэл, манлайлах чадварыг харгалзан 72 ментор албан хаагчийг тодорхой шалгуураар тодруулан, ментор албан хаагчдын нэгдсэн жагсаалт, мэдээллийн сан бүрдүүлсэн. 2025 оны 11 дүгээр сард төсөл танилцуулах, ментор албан хаагчдын өдөрлөгийг зохион байгуулж, салбарын албан хаагчаас авсан сэтгэл зүйн дархлааны суурь судалгааг танилцуулсан. Уг төслийн хүрээнд 2026 онд ментор албан хаагчдад зохион байгуулах “Төрийн байгууллагын бүтээмж”, “байгууллагын процессын зураглал”, “Хиймэл оюун ухаан” гэсэн чиглэлүүдээр цуврал сургалтуудыг зохион байгуулж ажиллахаар төлөвлөсөн .	100%
40	5.2.2.2	Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын албан хаагчдыг гадаад улс орнуудад туршлага судлуулах	Гадаадад туршлага судалсан албан хаагчийн тоо /тухайн жилд/	1	-	-	-	Тайлант хугацаанд НДГ-ын газраас 1 албан хаагчийг Солонгос улсын Дэгү хотод, 1 албан хаагчийг Шри-ланк улсад сургалтад хамруулж мэдлэгийг нь дээшлүүлсэн байна.	100%
41	5.2.2.3	Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын албан хаагчдыг “Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт”-д хамруулах	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	-	2	10.0	3.4	Удирдлагын академийн төрийн албан хаагчийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбараас 2 албан хаагч элсэн суралцаж, сургалтын төлбөрт 3.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан.	100%
42	5.2.2.4	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамруулах	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	-	24	10.0	16.3	Удирдлагын академийн төрийн албан хаагчийн дунд хугацааны давтан мэргэшүүлэх сургалтад ХХҮГ-аас 3 албан хаагч элсэн суралцаж, сургалтын төлбөрт 5.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан. Нийгмийн даатгалын газраас ОНТ-ийн 6.6 сая төгрөгийн санхүүжилтээр богино болон дунд хугацааны сургалтад нийт 18 албан хаагчийн хамруулж амжилттай төгссөн. ГТБХХГ-аас мэргэжлээ дээшлүүлэх, их дээд сургуульд эчнээ ангид суралцаж буй 3 албан хаагч албан хаагчид ОНТ-өөс 4.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100%

43	5.2.2.5	Албан хаагчдын хувийн хөгжил, стресс менежмент, ажил, амьдралын тэнцвэрийг хадгалах, ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулах	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-	209	10.0	-	Нийгмийн даатгалын газраас "Стрессгүй хамт олон төсөл"-ийн хүрээнд албан хаагчдын стрессийн түвшин, ажлын орчинд стресс үүсгэгч хүчин зүйлсийг тодорхойлох судалгаа авч, судалгаанд үндэслэн "Стрессийг танин мэдэх" сургалтыг 3 үе шаттайгаар зохион байгуулсан. Сургалтын дүнд албан хаагчид стресс даван туулах хувь хүний төлөвлөгөөтэй болсон байна. Албан хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор 8 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 131 албан хаагч хамрагдсан. Мөн 2025 оны байдлаар байцаагч, ажилтнуудыг чадавжуулах дотоодын сургалтыг 89 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 1284 албан хаагч хамрагдаж, 238182 хүн*цаг зарцуулан хүний нөөцийн хөгжил, ажилтны мэдлэг ур чадварт онцгой анхаарч ажилласан. Шинэ ажилтан бэлтгэх сургалтыг 4 удаа төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. ХХҮГ-аас ажилтан, албан хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор нийтдээ 6 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Орон нутагт зохион байгуулагдсан 8 удаагийн сургалтад давхардсан тоогоор 78 мэргэжилтэн оролцож сургалтаас олсон мэдлэгээ чадвар, дадал болгон ажиллаж байна.	100%
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа : 5.2.3.Нийгмийн салбарын хүний нөөцийн сэтгэл ханамжийг дээшлүүлж, албан хаагчдын амжилтыг үнэлж, урамшуулна.									
44	5.2.3.1	Салбарын тэмдэглэлт өдрүүд болон олон нийтэд чиглэсэн бусад үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан албан хаагчдыг урамшуулах	Албан хаагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	-	-	-	Нийгмийн салбарын ажилтны баярын өдрийг тохиолдуулан Орхон аймгийн Жаргалант суманд ХХҮГ, ХГБХХГ, НДГ гэсэн 3 байгууллагын хүрээнд гар бөмбөг, шатар, дардас, теннис гэх мэт спортын төрлүүдээр тэмцээн зохион байгуулсан. Нийлбэр дүнгээр Нийгмийн даатгалын газрын албан хаагчид 2 дугаар байр эзэлсэн. Нөхөрсөг спортын уралдаан тэмцээн зохион байгуулснаар нийгмийн салбарын байгууллагуудын хоорондын уялдаа холбоо сайжирч, цаашид хамтран ажиллах нөхцөл боломж бүрдэхийн зэрэгцээ , ажилтан албан хаагчдын эрүүл мэнд, сэтгэл зүйг дэмжсэн үр дүнтэй арга хэмжээ болсон.	100%
					Хэсгийн дүн	40.0	29.5		
ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД НИЙГМИЙН САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ХИЙГДЭХ АРГА ХЭМЖЭЭ									
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа : 5.2.2.Нийгмийн салбарын гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийн сургалт, хөгжлийг бодит хэрэгцээнд тулгуурлан дэмжиж, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, бүтээмжийг дээшлүүлж, судлаач албан хаагчдыг бэлтгэнэ.									
45	5.2.2.1	Нийгмийн салбарын ажилтнуудын эрдэм, шинжилгээ, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэн, судлаач албан хаагчдыг бэлтгэх.	Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдалтын хувь	-	71.4%	36.6	16.0	Нийгмийн салбарын бодлого, шинэчлэл" онол практикийн бага хуралд боловсролын салбараас-12, Эрүүл мэндийн салбараас-7, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, нийгмийн даатгалын газар, биеийн тамир спортынгазраас тус бүр 1, нийт 22 илтгэлийг хүлээн авч, эхний шалгаруулалтыг Удирдлагын академийн багш Доктор, дэд проф. Б.Нарантулга, Докторант Б.Ганзориг нар шүүж үүнээс 9 илтгэл 2 дугаар шатанд шалгарсан. Хоёрдугаар шатанд шалгарсан 9 илтгэлийн танилцуулга шалгаруулалт явагдаж, 9 багийн танилцуулга шалгаруулалтыг Удирдлагын академийн дээрх 2 багшаас гадна ШУТИС-ийн хүндэт профессор, доктор Ш.Ганбат оролцож, илтгэх танилцуулах чадвар, хугацаа баримталсан байдал, танилцуулгын загвар, бэлтгэл, асуултад хариулсан байдал гэсэн ерөнхий шалгуур үзүүлэлтээр дүгнэж шалгаруулсан. 1-р байранд: "Хүүхдийн суралцах хэв маягт тулгуурлан уншиж ойлгох чадварыг эцэг эхийн дэмжлэгээр хөгжүүлэх нь" сэдэвт илтгэл 2-р байранд: Гэрт ойр сургууль нь "Хамгийн сайн сургууль" байх боломж ба шийдэл сэдэвт илтгэл 3-р байранд: ЕБС-ийн хамран сургах тойргийг тогтооход "Газарзүйн мэдээллийн системийг ашиглах нь" сэдэвт илтгэл	100%

							Тусгай байранд: “Элэг, бөөр шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээ хийлгэсэн иргэд, донорын амьдралын чанарын судалгаа” сэдэвт илтгэл тус тус шалгарсан. Шагнал: 1-р байранд шалгарсан багт 3.0 сая төгрөгийн батламж, өргөмжлөл 2-р байранд шалгарсан багт 2.4 сая төгрөгийн батламж, өргөмжлөл 3-р байранд шалгарсан багт 1.8 сая төгрөгийн батламж, өргөмжлөл 4-р байр буюу тусгай байранд шалгарсан багт 1.2 төгрөгийн батламж, өргөмжлөл Бусад 5 баг тус бүрт 300,000 төгрөгийн батламж, өргөмжлөлийн хамт гардуулан өгсөн.	
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа : 5.2.3.Нийгмийн салбарын хүний нөөцийн сэтгэл ханамжийг дээшлүүлж, албан хаагчдын амжилтыг үнэлж, урамшуулна.								
46	5.2.3.1	Нийгмийн салбарын хүний нөөцийн сэтгэл ханамжийн судалгаа хийж албан хаагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулах	Албан хаагчдын сэтгэл ханамжийн хувь	23%	Судалгаа хийж суурь түвшинг тодорхойлох	10.0	10.2	100%
							<p>Энэ ажлын хүрээнд нийгмийн салбарын албан хаагчаас “Сэтгэл зүйн дархлааны түвшин”, “Сэтгэл ханамжийн судалгаа” гэсэн 2 төрлийн судалгааг авсан. Сэтгэл зүйн дархлааны судалгаанд салбарын 4700 албан хаагчаас 1788 албан хаагчид бүрэн хамрагдсан. Судалгаанд нийт албан хаагчдын 38.0% хамрагдаж, байгууллагын стрессийн суурь түвшин тодорхойлогдсон. Үүнээс боловсролын салбар-132.1, эрүүл мэндийн салбар-127.3, бусад салбар-128.7 буюу 3 салбар дунд түвшний стресстэй гэсэн дүгнэлт гарсан.</p> <p>Сэтгэл ханамжийн судалгаанд 520 хүн буюу нийт албан хаагчдын 11.0 хувийг хамруулсан. Судалгаанд хамрагдагчдын 87.5% эмэгтэй албан хаагчид 12.5% эрэгтэй албан хаагчид байна. Насны хувьд 34% нь 31-40 насны ид хөдөлмөрийн насны албан хаагчид байгаа бол 32,7% нь 41-50 насны албан хаагчид 17,5% нь 51-с дээш насны ахмад албан хаагчид байна. Судалгааны үр дүнгээс харахад:</p> <ul style="list-style-type: none"> •Ажлын орчин, хамт олны уур амьсгал, удирдлагын харилцаатай холбоотой үзүүлэлтүүдэд сэтгэл ханамж харьцангуй өндөр; •Харин цалин, урамшуулал, орлогын тогтвортой байдалтай холбоотой үзүүлэлтүүдэд сэтгэл ханамж сул байна. <p>Энэ нь байгууллагын дотоод зохион байгуулалт тодорхой хэмжээнд тогтвортой боловч материаллаг урамшууллын бодлогыг сайжруулах шаардлагатай байгааг илтгэж байна.</p> <p>Шинжилгээний үр дүнгээс харахад:</p> <ul style="list-style-type: none"> •0–5 жил ажилласан ажилтнуудын сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт хамгийн өндөр; •Ажилласан жил нэмэгдэхийн хэрээр сэтгэл ханамжийн түвшин алгуур буурах хандлага ажиглагдсан. <p>Төрийн албанд олон жил ажилласан байх тусам ажилтнуудын сэтгэл ханамж буурах хандлага илэрч байгаа нь цалин, урамшуулал, карьер хөгжлийн боломж хүлээлттэй нийцэхгүй байгаатай холбоотой байж болзошгүй гэж үзэх үндэслэлтэй. Нас, хүйсийн бүлгүүдийн хооронд сэтгэл ханамжийн зарим ялгаа ажиглагдсан боловч ажлын орчин, хамт олны уур амьсгалд мэдэгдэхүйц статистик ялгаа илрээгүй.</p> <p>Харин цалин, урамшуулалтай холбоотой үнэлгээ нь бүх нас, хүйсийн бүлгүүдэд ижил түвшинд сул байгаа нь нийтлэг асуудал болохыг харуулж байна.</p> <p>Нэгтгэн дүгнэвэл:</p> <ol style="list-style-type: none"> 1.Байгууллагын дотоод уур амьсгал, хамт олны байдал, ажлын орчин нөхцөлд ажилтнууд сэтгэл ханамжгүй биш байна. 2.Харин цалин, урамшуулал, өсөн дэвших боломжтой холбоотой асуудал сэтгэл ханамжийг бууруулах гол хүчин зүйл болж байна. 	

								3.Төрийн албанд олон жил ажилласан ажилтнуудын дунд сэтгэл ханамж буурах хандлага түлхүү илэрч байна. Иймд: •Олон жил ажилласан ажилтнуудад чиглэсэн ялгамжтай урамшууллын бодлого хэрэгжүүлэх •Бодлогын түвшинд карьер хөгжлийн, урамшууллын тодорхой, ил тод шатлал бий болгох •Ажлын ачаалал болон хийж буй ажил үүргийн гүйцэтгэлийг бодитоор, шударга үнэлэх тогтолцоог сайжруулах нь зүйтэй гэсэн дүгнэлт гарсан.	
Зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа : 5.2.4.Нийгмийн салбарын байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ									
47	5.2.4.1	Нийгмийн салбарын байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх	Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байгууллагын тоо	6	3	5.0 (Боловсрол)	5.0	Тайлант хугацаанд ерөнхий боловсролын 3 дугаар сургууль болон "Одод" цэцэрлэгт ISO чанарын стандартыг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд энэ ажлын хүрээнд 2 удаагийн сургалтыг байгууллагын багш, ажилтнуудад зохион байгуулж, хүний нөөцийг бэлтгэх мэргэшүүлэх сургалтад дээрх 2 байгууллагаас тус бүр 2 ажилтныг хамруулж бэлтгэл ажлыг үе шаттайгаар хангаж байна.	66.0%
Бусад үйл ажиллагаа									
48		Хөтөлбөрийн үр дүнг тайлагнах, сурталчлах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллах	-	-	-	10.0	6.0	Хөтөлбөрийн хүрээнд хүн амын бүлэгт чиглэсэн "Бүх хайраа гэр бүлдээ" төсөл, нийгмийн салбарын хүний нөөцөд чиглэсэн "Сэтгэл зүйн дархлаатай хамт олон" төсөл хэрэгжиж эхэлсэн. Бүх хайраа гэр бүлдээ төслийн брэндиг бий болгох, маркетинг концепцийг боловсруулалтад "Очиртзанабазар" медиа багтай хамтран ажилласан. "Бүх хайраа гэр бүлдээ" төслийн нээлтийг зохион байгуулж, нийт 120 гаруй байгууллагын эцэг эхийн зөвлөл, 26 багийн хамтарсан багийн төлөөлөл, гэр бүлүүд, болон өсвөр хүүхдүүд зэрэг 1000 гаруй хүн хамрагдсан. Мөн тухайн өдөр байгууллага, аж ахуйн нэгжүүдэд дотооддоо гэр бүлд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах чиглэл, удирдамжийг хүргүүлж ажлууд зохион байгуулагдсан. Мөн uuu.mn, ETV мэдээллийн сайт, аймгийн ЗДТГ-ын пэйж хуудсуудаар хөтөлбөрийг сурталчлах мэдээлэх ажлуудыг зохион байгуулсан	100%
						Хэсгийн дүн	61.6	37.2	
						Нийт	360.1	305.2	
						Нийт дүн	754.0	622.7	
Хэрэгжилтийн дундаж									92.6%